

Төсөл

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны  
... дүгээр тогтоолын гуравдугаар хавсралт

## **СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ЖИШИГ БАРИМТ БИЧИГ**

- I. ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭГЧ СОНГОХ УРЬДЧИЛСАН  
ШАЛГАРУУЛАЛТЫН БАРИМТ БИЧИГ
- II. ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭГЧ СОНГОХ УРАЛДААНТ  
ШАЛГАРУУЛАЛТЫН БАРИМТ БИЧИГ

I. ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭГЧ СОНГОХ УРЬДЧИЛСАН  
ШАЛГАРУУЛАЛТЫН БАРИМТ БИЧИГ

## Хувийн хэвшлийн түншлэгч сонгох уралдаант шалгаруулалтын урилга

Огноо: [огноо]

Уралдаант шалгаруулалтын нэр: [төслийн нэр]

Уралдаант шалгаруулалтын дугаар: [төслийн дугаар]

[Эрх бүхий этгээдийн нэр] нь Монгол Улсын болон гадаад улсын хуулийн этгээд, түүний нэгдэл [төслийн нэр]-ийн [түншлэлийн төрөл] төрлийн түншлэл олгох уралдаант шалгаруулалтад урьж байна.

[Түншлэлийн зүйлийн тодорхойлолт]

Түншлэл олгох уралдаант шалгаруулалтыг урьдчилсан болон уралдаант шалгаруулалтын [ I/II] үетэйгээр зохион байгуулна.

Урьдчилсан шалгаруулалтад оролцох хүсэлтэй этгээд нь [оролцогчид тавих үндсэн шаардлага] чадвартай байна.

Урьдчилсан шалгаруулалтын баримт бичгийг энэхүү урилгын дагуу оролцох хүсэлтээ албан бичгээр ирүүлж, эргэн төлөгдөхгүй нөхцөлөөр урьдчилсан шалгаруулалтын баримт бичгийн үнэ [урьдчилсан шалгаруулалтын баримт бичгийн үнэ] төгрөгийг [төлбөр хийх хэлбэр] төлж баримтыг ирүүлсэн этгээдэд олгоно.

Урьдчилсан шалгаруулалтад оролцох саналыг [оролцох санал хүлээн авах эцсийн хугацаа]-аас өмнө хүлээн авна.

Оролцох санал гаргагчийн урьдчилсан шалгаруулалтын баримт бичгийн дагуу ирүүлсэн оролцох саналыг үнэлж, урьдчилсан шалгаруулалтын баримт бичгийн шалгуур үзүүлэлтийг хамгийн сайн хангасан [оролцох санал гаргагчийг хязгаарлах тоо] хүртэлх оролцох санал гаргагчийг уралдаант шалгаруулалтад оруулна.

Уралдаант шалгаруулалтад Монгол Улсын болон гадаад улсын хуулийн этгээдийн нэгдэл оролцож болох бөгөөд тус түншлэлийг хэрэгжүүлэх зорилго, үйл ажиллагааны үндсэн чиглэл бүхий хуулийн этгээд (төслийн компани)-ийг байгуулж болно.

Сонирхсон этгээд оролцох хүсэлтээ дараах хаягаар ирүүлнэ үү.

[Эрх бүхий этгээдийн нэр]

[Хаяг]

[Хариуцах ажилтны нэр]

[Утас, факсын дугаар]

[E-майл хаяг]

[ТӨСЛИЙН НЭР] ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭГЧ СОНГОХ УРЬДЧИЛСАН  
ШАЛГАРУУЛАЛТЫН БАРИМТ БИЧИГ

Төслийн нэр:

Төслийн дугаар:

## **САНАМЖ**

Төр, хувийн хэвшлийн тухай хуулийн дагуу хувийн хэвшлийн түншлэгчийг сонгон шалгаруулалтын урьдчилсан шалгаруулалтын үе шатыг зохион байгуулахад энэ жишиг баримт бичгийг баримтална.

Энэхүү жишиг баримт бичгийн дагуу урьдчилсан шалгаруулалтыг зохион байгуулж, түншлэлийн төслийг хэрэгжүүлэх шаардлага хангасан буюу урьдчилсан шалгаруулалтад тэнцсэн оролцогчийн хураангуй жагсаалтыг гаргана.

Энэхүү тендерийн жишиг баримт бичгийн санамж болон бүлэг, зүйлийн оноосон нэр нь зөвхөн уг баримт бичгийг ойлгоход хялбар болгох зорилготой.

## **ГАРЧИГ**

1	Ерөнхий мэдээлэл.....	7
1.1	Урьдчилсан шалгаруулалтын баримт бичгийн зорилго.....	7
1.2	Нэр томъёоны тайлбар .....	8
1.3	Түншлэлийн төслийн танилцуулга .....	10
1.4	Төрийн түншлэгч:.....	10

1.5	Зохицуулах байгууллага: .....	10
2	Түншлэлийн төслийн мэдээлэл.....	10
2.1	Төслийн зорилго .....	10
2.2	Төслийн хамрах хүрээ, хувийн хэвшлийн үзүүлэх үйлчилгээ.....	11
2.3	Төслийн байршил .....	11
2.4	Түншлэлийн төслийн гол хүчин зүйл.....	11
2.5	Төрөөс үзүүлэх дэмжлэгийн тухай мэдээлэл .....	11
2.6	Ажлын даалгавар .....	11
2.7	Техникийн тодорхойлолт .....	11
2.8	Уралдаант шалгаруулалтын үе шат.....	11
2.9	Уралдаант шалгаруулалтын хуваарь* .....	12
3	Оролцогчдод өгөх зааварчилгаа .....	13
3.1	Үндсэн шаардлага .....	13
3.2	Хувийн хэвшлийн түншлэгч .....	14
3.3	Төслийн талбайтай танилцах .....	15
3.4	Оролцох санал гаргагч тодруулга хүсэх .....	15
3.5	Оролцох санал хүлээн авах эцсийн хугацаанаас өмнөх уулзалт .....	16
3.6	Урьдчилсан шалгаруулалтын баримт бичгийг хүчингүй болгох, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах .....	16
3.7	Оролцох санал гаргагчийн зардал .....	16
3.8	Оролцох санал ирүүлэх .....	16
3.9	Албан ёсны хэл.....	17
3.10	Оролцох саналд нэмэлт, өөрчлөлт оруулах, буцааж авах.....	17
3.11	Оролцох санал хүлээн авах, мэдээлэл хийх.....	17
3.12	Нууцлал .....	17
3.13	Уралдаант шалгаруулалтын ажлын хэсэг тодруулга хүсэх.....	18
4	Оролцох саналын үнэлгээ .....	18
4.1	Оролцох саналын иж бүрдэл.....	18
4.2	Үнэлгээний шалгуур үзүүлэлтүүд .....	18
4.3	Оролцох саналыг үнэлэх .....	18
5	Оролцох саналын жишиг маягтууд .....	20

## **1 Ерөнхий мэдээлэл**

### **1.1 Урьдчилсан шалгаруулалтын баримт бичгийн зорилго**

Энэхүү урьдчилсан шалгаруулалтын баримт бичигт [төслийн нэр] ерөнхий мэдээлэл, түншлэлийн төслийн танилцуулга, оролцох санал гаргагчдад өгөх зааварчилгаа, оролцох саналын үнэлгээний тухай мэдээлэл, оролцох саналын маягтуудыг багтаасан болно. Эрх бүхий этгээд оролцох саналыг оролцогчид тавих үндсэн шаардлагын дагуу үнэлж, шалгуур үзүүлэлтийг хангасан оролцох санал гаргагчдаар хязгаарлан төслийн саналаа ирүүлэх эрх бүхий оролцогчдын хураангуй жагсаалтыг гаргаж, тэдгээрт мэдэгдэн уралдаант шалгаруулалтын баримт бичгийг олгох зэрэг ажлыг зохион байгуулахад энэхүү урьдчилсан шалгаруулалтын баримт бичгийн зорилго оршино. Энэхүү урьдчилсан шалгаруулалтын баримт бичигт туссан

мэдээллүүд нь урьдчилсан байдлаар өгөгдөж байгаа бөгөөд дараагийн шатны уралдаант шалгаруулалтын баримт бичигт өөрөөр заасан тохиолдолд уралдаант шалгаруулалтын баримт бичгийг дагана.

## 1.2 Нэр томъёоны тайлбар

- 1.2.1 “гишүүн компани” гэж хувийн хэвшлийн түншлэгчийг бүрдүүлж буй түүнд орсон хуулийн этгээдийг;
- 1.2.2 “зохицуулах байгууллага” гэж түншлэлийг хэрэгжүүлэхэд шаардлагатай зөвшөөрөл, тусгай зөвшөөрөл олгох, үнэ тариф тогтоох, түншлэлийн зүйл эсхүл түүгээр үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон дүрэм, журмыг батлах, мөрдүүлэх үүрэг бүхий төрийн байгууллагыг;
- 1.2.3 "Засгийн газрын зөвшөөрөл" гэж түншлэлийн хүрээнд холбогдох хууль тогтоомжийн дагуу төрийн байгууллагаас олгох шаардлагатай зөвшөөрөл, лиценз, тусгай зөвшөөрөл, бүртгэлийг;
- 1.2.4 "санхүүжүүлэгч" гэж хувийн хэвшлийн түншлэгчид төсөл хэрэгжүүлэхтэй холбогдуулан зээл олгож байгаа болон түншлэлийн төсөлд санхүүгийн баталгаа гаргах, санхүүгийн бусад дэмжлэг үзүүлж байгаа хувьцаа эзэмшигчээс бусад банк, санхүүгийн байгууллагыг
- 1.2.5 "түншлэлийн гэрээ" гэж төрийн болон хувийн хэвшлийн түншлэгч талуудын хооронд түншлэлийн төслийг хэрэгжүүлэхээр харилцан тохиролцож, талуудын эрх, үүрэг болон холбогдох бусад асуудлыг тодорхойлж байгуулсан иргэний эрх зүйн гэрээг;
- 1.2.6 "төрийн түншлэгч" гэж түншлэлийн гэрээг хэрэгжүүлэх тухайн салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон түншлэлийн гэрээнд заасны дагуу энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан бусад этгээдийг



- 1.2.7 "хувийн хэвшлийн түншлэгч" гэж төрийн түншлэгчтэй түншлэлийн гэрээ байгуулж, энэ хуульд заасан түншлэлийн төслийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Компанийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын тухай хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан гадаад, дотоодын хөрөнгө оруулалттай хуулийн этгээд болон хуулийн этгээдийн нэгдлийг;
- 1.2.8 "Оролцох хүсэлт" гэж уралдаант шалгаруулалтын зар мэдээний дагуу урьдчилсан шалгаруулалтад оролцохоор Монгол Улсын болон гадаад улсын хуулийн этгээд, түүний нэгдлээс ирүүлсэн албан бичгийг
- 1.2.9 "Оролцох санал" гэж оролцох хүсэлт гаргасан этгээдээс урьдчилсан шалгаруулалтын баримт бичгийн дагуу ирүүлсэн саналыг;
- 1.2.10 "Оролцох санал гаргагч" гэж урьдчилсан шалгаруулалтын баримт бичгийн дагуу оролцох саналаа ирүүлсэн этгээдийг;
- 1.2.11 "Оролцогч" гэж урьдчилсан шалгаруулалтад тэнцсэн этгээдийг;
- 1.2.12 "Төслийн санал" гэж оролцогчдоос уралдаант шалгаруулалтын баримт бичгийн дагуу ирүүлсэн саналыг;
- 1.2.13 "тусгай зориулалтын компани" гэж түншлэлийн гэрээний хүрээнд хувийн хэвшлийн түншлэгчийн үүргийг хүлээж, түншлэлийн төслийг хэрэгжүүлэх тусгай зориулалтаар хувийн хэвшлийн түншлэгчээс үүсгэн байгуулсан төслийн компанийг
- 1.2.14 "сонгон шалгаруулалтын ажлын хэсэг" гэж Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 24.1-т заасан ажлын хэсгийг;
- 1.2.15 "Урьдчилсан шалгаруулалт" гэж Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 25.1-ээс 25.5 дах хэсэгт заасан сонгон шалгаруулалтын үе шатыг
- 1.2.16 "Урьдчилсан шалгаруулалтын баримт бичиг" гэж Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 25.2.2-т заасан шалгуур үзүүлэлтүүд, шаардлагатай бусад мэдээллийг тусгасан баримт бичгийг;
- 1.2.17 "Уралдаант шалгаруулалт" гэж Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 25 дугаар зүйлд заасан сонгон шалгаруулах үйл ажиллагааг;
- 1.2.18 "Уралдаант шалгаруулалтын хуваарь" гэж уралдаант шалгаруулалтын нарийвчилсан төлөвлөгөөг;
- 1.2.19 "Уралдаант шалгаруулалтын баримт бичиг" гэж оролцогчдод олгох Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 25.6.2-д заасан шалгуур үзүүлэлтүүд, шаардлагатай бусад мэдээллийг тусгасан баримт бичгийг;
- 1.2.20 "мөнгөний үнэ цэнэ" гэж түншлэлийн төслийн хэрэгжилтийн бүх үе шатанд төслийн нийт өртгөөр төслийн үйлчилгээг чанар, хүртээмж, үр ашиг, өгөөжтэй байх хувилбарыг тогтоохыг;

- 1.2.21 "санхүүгийн чадавхад нийцсэн" гэж түншлэлийн хүрээнд үзүүлж байгаа үйлчилгээнд хэрэглэгчээс авах хураамж, төсвөөс санхүүжүүлэх санхүүжилт нь хэрэглэгчийн болон төсвийн чадавхад нийцсэн байх, төсвийн хувьд зардал болон болзошгүй өр төлбөрийг орлогоос шийдвэрлэх боломжтой байхыг;
- 1.2.22 "төсөвт үзүүлэх нөлөө" гэж төслийг хэрэгжүүлэхэд төсөв, санхүүд үзүүлэх нөлөөллийг тооцох, шууд болон шууд бус байдлаар төлбөрийн үүрэг хариуцлагыг бий болгох болзошгүй нөхцөл байдлыг
- 1.2.23 "төслийн орлого" гэж хэрэглэгчийн төлбөр, хураамж болон түншлэлийн гэрээний хүрээнд бий болсон төслийн орлогын эх үүсвэрийг;
- 1.2.24 "түншлэлийн зүйл" гэж түншлэлийн гэрээнд хамаарах эд хөрөнгийн эрх, ажил, үйлчилгээний үр дүн, хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгийг;
- 1.2.25 "түншлэлийн төсөл" гэж нийтийн зориулалттай дэд бүтэц, төрийн үйлчилгээний салбарт нийтийн хэрэгцээ, шаардлагыг хангах зорилгоор хувийн хэвшлийн түншлэгч хөрөнгө оруулалт хийх, зураг төсөл боловсруулах, дэд бүтцийн барилга, байгууламжийг барих, санхүүжүүлэх, сэргээн босгох, сайжруулах, засвар арчлалт хийх, төрийн үйлчилгээг үзүүлэх, төрийн үйлчилгээний удирдлагыг хариуцах зэрэг үйл ажиллагааг багтаасан нийтэд чиглэсэн төслийг;
- 1.2.26 "хэрэглэгчийн төлбөр" гэж нийтийн зориулалттай дэд бүтэц, төрийн үйлчилгээг ашигласны төлөө хэрэглэгчээс төлөх төлбөр, хураамжийг;
- 1.3 Түншлэлийн төслийн танилцуулга  
[Төслийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаргасан хууль тогтоомж, бодлого шийдвэр, барилгын ажлыг гүйцэтгэх хугацаа, төсөвлөсөн нийт өртөг гэх мэт мэдээллийг дэлгэрэнгүй оруулах]
- 1.4 Төрийн түншлэгч:  
[Төслийн нэр]-ийг хэрэгжүүлэх төрийн түншлэгч нь [байгууллагын нэр] байна.  
[Байгууллагын танилцуулга, хуулиар олгогдсон эрх, үүргийн талаар танилцуулга, тайлбар]
- 1.5 Зохицуулах байгууллага:  
[Төслийн нэр]-ийн зохицуулах байгууллагад дараах байгууллага орно:  
[Зохицуулах байгууллагуудын нэр]  
[Зохицуулах байгууллагуудын төсөлд гүйцэтгэх үүрэг, түүний хууль эрх зүйн үндэслэл]

## **2 Түншлэлийн төслийн мэдээлэл**

### **2.1 Төслийн зорилго**

[Төслийн зорилго, эрэлт хэрэгцээ, нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөө, хүлээгдэж байгаа үр дүнг дэлгэрэнгүй бичих]

## 2.2 Төслийн хамрах хүрээ, хувийн хэвшлийн үзүүлэх үйлчилгээ

Хувийн хэвшлийн түншлэгч нь [төслийн нэр] түншлэлийн төслийг [Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлд заасан түншлэлийн гэрээний төрөл] хэлбэрээр хэрэгжүүлж [төслийн хүрээнд хийгдэх зураг төсөл, барилгын ажил, хөрөнгө оруулалт, ашиглалтын үйл ажиллагаа, засвар арчлалтын гэх мэт ажлуудыг тодорхойлж бичих] ажлуудыг гүйцэтгэнэ.

## 2.3 Төслийн байршил

[харьяалагдах засаг захиргааны нэгж]-ийн нутаг дэвсгэрт, [байршил болон бусад тодорхойлолтыг бичих]-т байршилтай байна. [түншлэлийн зүйлийн байршлыг зэргэлдээ газар, газар эзэмшигчдийн мэдээллийн хамт харуулсан газрын зургийг оруулах, эсхүл хавсралтаар үзүүлэх].

## 2.4 Түншлэлийн төслийн гол хүчин зүйл

[Төслийн хэрэгжих хугацаа, санхүүжилтийн төрөл, түншлэлийн зүйлийн талаарх мэдээлэл, түншлэлийн төрөл, төслийн зардлыг санхүүжүүлэх хэлбэр, түншлэлийн гэрээний гол нөхцөлүүд, хувийн хэвшлийн түншлэгчийн эрх үүрэг, эрсдэл хуваарилалт, төслийн хөрөнгө оруулалтын эх үүсвэр, хэмжээ болон төлөвлөгөө]

## 2.5 Төрөөс үзүүлэх дэмжлэгийн тухай мэдээлэл

[Төрөөс үзүүлэх дэмжлэгийн тухай мэдээлэл]

## 2.6 Ажлын даалгавар

[Ажлын даалгавар]

## 2.7 Техникийн тодорхойлолт

[нарийвчилсан техник- эдийн засгийн үндэслэл, бусад судалгааны материалын талаарх мэдээллийг оруулах].

## 2.8 Уралдаант шалгаруулалтын үе шат

2.8.1 уралдаант шалгаруулалтын ажлын хэсэг (цаашид “ажлын хэсэг” гэх) нь уралдаант шалгаруулалтыг урьдчилсан болон уралдаант шалгаруулалтын гэсэн хоёр үетэйгээр зохион байгуулна.

2.8.2 урьдчилсан шалгаруулалт:

Оролцох саналыг “Уралдаант шалгаруулалтын санал үнэлэх журам”-ын дагуу үнэлж, энэхүү урьдчилсан шалгаруулалтын баримт бичигт тусгасан шалгуур үзүүлэлтийг хамгийн сайн хангаж, 60 буюу түүнээс дээш оноо авсан нийт [оролцогчдын тоо] оролцогчоор хязгаарлан оролцогчдын жагсаалт гаргана.

2.8.3 Уралдаант шалгаруулалт:

Оролцогчдын жагсаалтад багтсан этгээд уралдаант шалгаруулалтын баримт бичгийн дагуу төслийн саналаа ирүүлнэ. Уралдаант шалгаруулалтын баримт бичигт төслийн саналын иж бүрдэл, түүнийг үнэлэх шалгуур үзүүлэлтийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг багтаасан байна.

2.8.3.1 төслийн саналын техникийн саналын үнэлгээний шалгуур үзүүлэлтэд нь дараах зүйлээс бүрдэнэ:

- техникийн үзүүлэлт, үйл ажиллагааны үнэлгээ;
- үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмж;
- түншлэлийн гэрээний төслийн ерөнхий нөхцөлийн үнэлгээ;
- байгаль орчныг хамгаалах шаардлага хангаж байгаа эсэх.

2.8.3.2 төслийн саналын санхүүгийн саналын үнэлгээний шалгуур үзүүлэлт нь дараах зүйлээс бүрдэнэ:

- санхүүгийн загварын үнэлгээ;
- төслийн зардлын үнэлгээ;
- санхүүжилтийн төлөвлөгөө;
- улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилд үзүүлэх нөлөө.

## 2.9 Уралдаант шалгаруулалтын хуваарь\*

Уралдаант шалгаруулалтыг дараах хуваарийн дагуу зохион байгуулна:

<b>Агуулга</b>	<b>Огноо:</b>
Урьдчилсан шалгаруулалтын баримт бичиг олгож эхлэх	[огноо]
Оролцох санал хүлээн авах эцсийн хугацаа	[огноо] цагаас өмнө
Оролцогчдын богино жагсаалт гаргах	[огноо]
Уралдаант шалгаруулалтын баримт бичиг олгож эхлэх	[огноо]
Төслийн санал хүлээн авах эцсийн хугацаа	[огноо] цагаас өмнө
Оролцогчдын дараалуулсан жагсаалт гаргах	[огноо]
Түншлэлийн гэрээнд гарын үсэг зурах	[огноо]

*\*Ажлын хэсэг уралдаант шалгаруулалтын хуваарьт өөрчлөлт оруулж болно.*

### 3 Оролцогчдод өгөх зааварчилгаа

#### 3.1 Үндсэн шаардлага

- 3.1.1 оролцох санал гаргагчид тавих үндсэн шаардлагыг хангасан, уралдаант шалгаруулалтын урилгад тусгасан шаардлагын дагуу оролцох хүсэлт гаргаж, энэхүү урьдчилсан шалгаруулалтын баримт бичгийг авсан хуулийн этгээд, эсхүл түүний нэгдэл (цаашид “хувийн хэвшлийн түншлэгч” гэх) оролцох санал ирүүлэх эрхтэй.
- 3.1.2 Дараах тохиолдолд оролцох санал гаргагчид тавих үндсэн шаардлагыг хангаагүй гэж үзнэ:
- 3.1.2.1 төлбөрийн чадваргүй болсон, татан буугдаж байгаа, дампуурлаас зайлсхийх зорилгоор зээлдүүлэгчтэй тохиролцсон, бизнесийн үйл ажиллагааг нь зогсоосон эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу дээр дурдсантай адилтгах нөхцөлд байгаа
  - 3.1.2.2 Монгол Улсын эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө төлөөгүй;
  - 3.1.2.3 сүүлийн 3 жилийн хугацаанд худалдан авах ажиллагаанд оролцохдоо гэрээний үүргээ ноцтой зөрчсөн, биелүүлээгүй, эсхүл мэргэжлийн үйл ажиллагаанд алдаа гаргасныг шүүх, эрх бүхий байгууллага тогтоосон
  - 3.1.2.4 илт худал мэдээлэл ирүүлснийг эрх бүхий байгууллага тогтоосон;
  - 3.1.2.5 энэхүү урьдчилсан шалгаруулалтад хоёр буюу түүнээс дээш оролцох санал гаргагчийн хууль ёсны төлөөлөгч нь нэг этгээд бол;
  - 3.1.2.6 сүүлийн 3 жилийн хугацаанд Авлигын тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль болон Эрүүгийн хуульд заасан авлига, залилан мэхлэх, зохиомол тохиролцоо хийх, айлган сүрдүүлэх үйлдлийн аль нэгэнд холбогдсон болохыг шүүх тогтоосон
  - 3.1.2.7 аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд заасны дагуу тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх аж ахуйн үйл ажиллагааны хувьд уг зөвшөөрлийг авах шаардлагыг хангаагүй байх
  - 3.1.2.8 төслийг хэрэгжүүлэх санхүүгийн чадавх, удирдлага, мэргэжлийн хүний нөөц, техник, технологийн чадвар, ажлын туршлагатай байх;
  - 3.1.2.9 Зөвшөөрлийн тухай хуульд заасны дагуу энгийн болон тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх аж ахуйн үйл ажиллагааны хувьд уг зөвшөөрлийг авах шаардлагыг хангасан байх;
  - 3.1.2.10 тухайн хуулийн этгээдийг татан буулгах, дампуурлыг зарлах үйл ажиллагаа эхлээгүй, эд хөрөнгийг нь битүүмжлээгүй, үйл ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зогсоогоогүй байх;
  - 3.1.2.11 сүүлийн 3 жилийн хугацаанд түншлэлийн гэрээг биелүүлээгүй тухай шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр гараагүй байх;
  - 3.1.2.12 хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигч, компанийн эрх бүхий албан тушаалтан нь ял шийтгэлгүй, төрийн түншлэгч этгээдийн удирдах албан тушаалтантай нэгдмэл сонирхолгүй, эсхүл хамаарал бүхий этгээд биш, ашиг сонирхлын зөрчилгүй байх;

- 3.1.2.13 сонгон шалгаруулалтад оролцогч компанийн эцсийн өмчлөгч болон хараат, охин компани нь харилцан хамааралгүй байх;
- 3.1.2.14 сонгон шалгаруулалтад оролцогчид нь Өрсөлдөөний тухай хуулийн 4.1.6-д заасны дагуу харилцан хамааралгүй байх.
- 3.1.2.15 Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 27.5 дах хэсэгт заасан эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлд ороогүй байх
- 3.1.2.16 Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжид заасан ашиг сонирхлын зөрчил үүсээгүй байх.
- 3.1.2.17 Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээд болон тэдгээрийн эрх бүхий албан тушаалтан хувийн хэвшлийн түншлэгчийн сонгон шалгаруулалтад оролцох эрхгүй байна
- 3.1.2.18 Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээд хувийн хэвшлийн түншлэгч компани, эсхүл тусгай зориулалттай компанийн хувьцаа эзэмшигч байхыг хориглоно.
- 3.1.3 оролцох санал гаргагч нь 3.2-т заасан нөхцөл байдал үүссэн эсэх мэдэгдлийг эрх бүхий этгээдэд бичгээр гаргаж өгөх үүрэгтэй. Эдгээр нөхцөл үүссэн эсэхийг магадлах зорилгоор эрх бүхий этгээдээс тавьсан шаардлагын дагуу оролцох санал гаргагч холбогдох баримт, нотолгоог эрх бүхий этгээдэд ирүүлнэ
- 3.1.4 оролцох санал гаргагч урьдчилсан шалгаруулалтад оролцохдоо хуурамч материал, баримт, нотолгоо ирүүлсэн нь илэрсэн тохиолдолд эрх бүхий этгээд оролцох саналд үндэслэн байгуулсан аливаа гэрээ, хэлцлийг цуцлах эрхтэй бөгөөд гэрээ, хэлэлцээрийг цуцалснаас учирсан хохирлыг оролцох санал гаргагч өөрөө хариуцна\_
- 3.1.5 төслийн саналын баримт бичгийг хуурамчаар бүрдүүлсэн, эсхүл бүрдэл дутуу ирүүлсэн нь оролцогчийн төслийн саналыг буцаах үндэслэл болно
- 3.2 Хувийн хэвшлийн түншлэгч
  - 3.2.1 Монгол Улсын болон гадаад улсын хуулийн этгээдийн нэгдлээс бүрдсэн түншлэл хамтран ажиллах гэрээний үндсэн дээр уралдаант шалгаруулалтад оролцож болох бөгөөд дараах шаардлагыг хангасан байна

- 3.2.1.1 түншлэлийн гэрээг хэрэгжүүлэхэд бүх гишүүн компани хамтран болон тус тусдаа хүлээх хариуцлагыг хамтран ажиллах гэрээнд тусгасан байх;
- 3.2.1.2 түншлэлийн аль нэг болон бүх гишүүний нэрийн өмнөөс үүрэг хүлээх, зааварчилгаа хүлээн авах, төлбөр тооцоо хийхэд тэдгээрийг төлөөлөх эрх бүхий нэг гишүүнийг итгэмжлэлээр томилсон байх.

Жич: Урьдчилсан шалгаруулалтын шалгуур үзүүлэлтүүд нь хувийн хэвшлийн түншлэгч нэгдлийг бүрдүүлж буй хуулийн этгээдүүд бүхэлд нь хамаарна. Хувийн хэвшлийн түншлэгч нь энэхүү урьдчилсан шалгаруулалтын болон уралдаант шалгаруулалтын үед тусгай зориулалтын компани байгуулж болох бөгөөд энэ тухай түншлэлийн гэрээнд зааж болно. тусгай зориулалтын компанийн бүтэц, зохион байгуулалттай холбоотой харилцааг Төр, хувийн хэвийн түншлэлийн тухай хуулийн 42 дүгээр зүйлд заасны дагуу хэрэгжүүлнэ.

Гишүүн компани нь тусгай зориулалтын компанид хувь нийлүүлэгч, эсхүл гүйцэтгэгчээр оролцож болно. Хувийн хэвшлийн түншлэгчийн гишүүн компани нь ижил төслийн уралдаант шалгаруулалтад өөр түншлэгчийн гишүүнээр эсхүл бие даан оролцож болохгүй.

### 3.3 Төслийн талбайтай танилцах

- 3.3.1 оролцох санал гаргагч төслийн талбай, түүний байршил, орчин тойрны нөхцөл байдалтай газар дээр нь судлан танилцаж, төслийн санал бэлтгэхэд шаардлагатай мэдээллийг олж авч болно. Төслийн талбайтай газар дээр нь очиж танилцах зардлыг оролцох санал гаргагч өөрөө хариуцна

### 3.4 Оролцох санал гаргагч тодруулга хүсэх

- 3.4.1 оролцох санал гаргагч нь урьдчилсан шалгаруулалттай холбоотой аливаа тодруулга авах хүсэлтийг доорх хаягийн дагуу бичгээр гаргана.

[Ажлын хэсгийн нарийн бичгийн даргын хаяг, холбоо барих мэдээлэл]

- 3.4.2 ажлын хэсгийн нарийн бичгийн дарга нь тодруулга хүссэн албан бичгийг эрх бүхий этгээдийн бичиг хэргээр дамжуулан хүлээн авч ажлын хэсгийн даргад танилцуулна. Ажлын хэсгийн дарга тодруулга өгөх ажлыг зохион байгуулна. Тодруулгыг бүх оролцох санал гаргагчид зэрэг явуулна. Тодруулга авах хүсэлтийг оролцох санал хүлээн авах эцсийн хугацаанаас хамгийн багадаа 10 (арван) өдрийн өмнө ирүүлэх бөгөөд хоцорч ирүүлсэн хүсэлтэд хариу өгөхгүй.

### 3.5 Оролцох санал хүлээн авах эцсийн хугацаанаас өмнөх уулзалт

3.5.1 ажлын хэсэг нь оролцох санал хүлээн авах эцсийн хугацаанаас өмнөх уулзалт [зохион байгуулах тоо, уулзалт хийх газар, огноо]-ыг зохион байгуулна.

### 3.6 Урьдчилсан шалгаруулалтын баримт бичгийг хүчингүй болгох, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах

3.6.1 эрх бүхий этгээд нь урьдчилсан шалгаруулалтын баримт бичгийг уралдаант шалгаруулалтын аль ч үед хүчингүй болгох эрхтэй бөгөөд үүнээс үүдэн оролцох санал гаргагчид учирсан аливаа зардал, хохирлыг хариуцахгүй.

3.6.2 ажлын хэсэг оролцох санал хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө урьдчилсан шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Энэ тохиолдолд оролцох санал хүлээн авах эцсийн хугацааг нэмэлт, өөрчлөлт оруулсан өдрөөс хойш 5 (тав)-аас доошгүй өдрөөр сунгана. Нэмэлт, өөрчлөлт нь урьдчилсан шалгаруулалтын баримт бичгийн салшгүй хэсэг болох бөгөөд түүнийг оролцох санал гаргагчдад нэгэн зэрэг мэдэгдэнэ

### 3.7 Оролцох санал гаргагчийн зардал

3.7.1 оролцох санал гаргагч өөрийн оролцох саналаа бэлтгэх, ажлын хэсэгт ирүүлэхтэй холбогдон гарах бүх зардлыг хариуцна.

### 3.8 Оролцох санал ирүүлэх

3.8.1 оролцох саналыг 1 (нэг) эх хувь, [шаардлагатай хуулбар хувийн тоо] хуулбар хувь, 1 (нэг) цахим хувь бэлтгэн тус тусад нь “ЭХ ХУВЬ”, “ХУУЛБАР ХУВЬ”, “ЦАХИМ ХУВЬ” гэсэн тэмдэглэгээ бүхий дугтуйнуудад (дотор дугтуй) хийж битүүмжлэн, тэдгээрийг дахин давхар нэг дугтуйнд хийж битүүмжилнэ (гадна битүүмжлэл). Цахим хувийг PDF хэлбэрээр бэлтгэн, зөөврийн санах ой /flash disk/-нд буулгасан байна

3.8.2 оролцох саналыг доорх хаягаар [оролцох санал хүлээн авах эцсийн хугацаа]-аас өмнө ирүүлэх бөгөөд заасан хугацаанаас хоцорсон, гадна битүүмжлэлийн шаардлагыг хангаагүй бол оролцох саналыг хүлээж авахгүй.

[ажлын хэсгийн нарийн бичгийн даргын хаяг]



3.8.3 оролцох саналыг ирүүлэхдээ дотор болон гадна дугтуйн зүүн дээд буланд дараах мэдээллийг бичнэ:

3.8.3.1 урьдчилсан шалгаруулалтын баримт бичгийн дугаар;

3.8.3.2 төслийн нэр;

3.8.3.3 оролцох санал хүлээн авах эцсийн хугацаа;

3.8.3.4 дээрх хугацаанаас өмнө “НЭЭЖ ҮЛ БОЛНО” гэсэн тэмдэглэгээ;

3.8.3.5 оролцох санал ирүүлэх хаяг;

3.8.3.6 оролцох санал гаргагчийн нэр, хаяг.

3.8.4 урьдчилсан шалгаруулалтын баримт бичигт заасан тоо ширхэг, тэмдэглэгээнээс зөрүүтэй, дотор дугтуйн битүүмжлэл урьдчилсан шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлагыг хангаагүй бол оролцох саналыг урьдчилсан шалгаруулалтад тэнцээгүй гэж үзнэ.

3.9 Албан ёсны хэл

3.9.1 урьдчилсан шалгаруулалттай холбоотой аливаа харилцааг [монгол, эсхүл англи] хэлээр явуулна. Оролцох саналын иж бүрдлийг [монгол, эсхүл англи хэл] дээр бэлтгэж ирүүлнэ.

3.10 Оролцох саналд нэмэлт, өөрчлөлт оруулах, буцааж авах

3.10.1 оролцох санал гаргагч нь санал хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө өөрийн оролцох саналдаа нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Саналд нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд оролцох санал хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө энэ тухай албан бичгээр хүсэлт гарган, нэмэлт, өөрчлөлт оруулсан саналаа ажлын хэсэгт ирүүлнэ. Ажлын хэсэг өмнө нь ирүүлсэн саналыг нээлгүйгээр эргүүлэн олгоно

3.10.2 оролцох санал гаргагч санал хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө хэдийд ч албан бичгээр хүсэлт гарган оролцох саналаа буцаан авч болно

3.11 Оролцох санал хүлээн авах, мэдээлэл хийх

3.11.1 ажлын хэсгийн нарийн бичгийн дарга [оролцох санал хүлээн авах эцсийн хугацаа]-аас өмнө ирүүлсэн оролцох саналын гадна битүүмжлэл, тэмдэглэгээг шалган энэхүү урьдчилсан шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлагыг хангасан бол бүртгэн хүлээж авах бөгөөд шаардлага хангаагүй бол хүлээж авахгүй.

3.11.2 ажлын хэсгийн нарийн бичгийн дарга [мэдээлэл хийх газар, огноо, цаг]-т оролцох санал гаргагчдын талаар мэдээлэл хийнэ. Мэдээлэл хийх үед оролцох санал гаргагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч болон сонирхсон бусад этгээд байлцаж болно. Мэдээлэл хийх үед хийсэн тэмдэглэлд ажлын хэсгийн нарийн бичгийн дарга болон байлцсан бусад этгээд гарын үсэг зурна.

3.12 Нууцлал

- 3.12.1 оролцох саналыг хянан үзэх, үнэлэхтэй холбогдсон аливаа мэдээллийг оролцох санал гаргагчид болон тухайн урьдчилсан шалгаруулалтын үйл ажиллагаатай албан ёсоор холбогдолгүй аливаа этгээдэд задруулахыг хориглоно.
- 3.12.2 оролцох саналыг хянан үзэх, үнэлэх явцад оролцох санал гаргагчаас нөлөөлөх гэсэн аливаа оролдлого нь тухайн оролцох санал гаргагчийн оролцох саналаас татгалзах үндэслэл болж болно.
- 3.12.3 урьдчилсан шалгаруулалт явагдаж дуусмагц оролцох санал гаргагчдын ирүүлсэн оролцох саналын хуулбар хувиудыг устгах бөгөөд эх хувийг зохих журмын дагуу уралдаант шалгаруулалтын хавтаст хэргийн хамт архивд шилжүүлнэ

### 3.13 Уралдаант шалгаруулалтын ажлын хэсэг тодруулга хүсэх

- 3.13.1 оролцох саналтай холбоотой аливаа тодруулга авах хүсэлтийг ажлын хэсэг эрх бүхий этгээдийн албан бичгээр оролцох санал гаргагчид хүргүүлнэ. Оролцох санал гаргагч нь хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 5 (таван) өдрийн дотор тодруулгыг бичгээр ирүүлнэ

## 4 Оролцох саналын үнэлгээ

### 4.1 Оролцох саналын иж бүрдэл

- 4.1.1 оролцох санал нь уг төслийг хэрэгжүүлэхэд оролцох санал гаргагчаас шаардагдах шалгуур үзүүлэлтийг хангасан гэдгийг нотлон харуулах зорилготой байна. Оролцох санал нь 5 дугаар бүлэгт заасан оролцох саналын маягтууд, тэдгээрийн дагалдах хавсралтууд энэхүү баримт бичгийн 3.1-д заасан нөхцөл байдал үүсэж байсан бол үүссэн нөхцөлийг арилгасан тухай холбогдох баримт, нотолгооноос бүрдэнэ.

### 4.2 Үнэлгээний шалгуур үзүүлэлтүүд

- 4.2.1 үндсэн шаардлага
- 4.2.2 санхүүгийн чадавх
- 4.2.3 техник, технологийн чадвар

### 4.3 Оролцох саналыг үнэлэх

- 4.3.1 Оролцох санал гаргагч нь үндсэн шаардлагыг хангасан эсэхийг дараах мэдээлэл, нотлох баримтад үндэслэн тогтооно:
  - 4.3.1.1 хуулийн этгээд, эсхүл гишүүн компаниудын бүртгүүлсэн газар, бизнесийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, хаягийг тодорхойлсон улсын бүртгэлийн гэрчилгээний эхээс хийсэн хуулбар, эсхүл үүсгэн байгуулагдсаныг нотлох түүнтэй адилтгах бусад баримт бичиг
  - 4.3.1.2 оролцох санал гаргагч, эсхүл хувийн хэвшлийн түншлэгч, түүний гишүүн компаниудыг төлөөлөх эрх олгосон этгээдийн итгэмжлэл
  - 4.3.1.3 хуулийн этгээдүүдийн нэгдлийн хувьд талууд хамтран ажиллахаа илэрхийлсэн хамтран ажиллах гэрээний хуулбар;

- 4.3.1.4 энэхүү баримт бичгийг 3.2-т дурдсан нөхцөл байдал үүсэж байсан бол энэ тухайгаа уралдаант шалгаруулалтын ажлын хэсэгт мэдэгдэж, холбогдох эрх бүхий байгууллагын гаргасан шийдвэр, тухайн нөхцөл байдал арилсан тухай холбогдох баримт, нотолгоо
- 4.3.2 Санхүүгийн чадавхын үнэлгээгээр оролцох санал гаргагчийн санхүүгийн чадавх болон уг төслийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг бүрдүүлэх чадавхыг үнэлнэ.
- 4.3.3 Техник, технологийн чадварын үнэлгээгээр оролцох санал гаргагч төслийг хэрэгжүүлэхэд шаардагдах туршлага, удирдлага, хүний нөөцийн чадавх, ижил төстэй төсөл хэрэгжүүлсэн туршлага, техник хэрэгсэл, технологийн чадвартай эсэхийг үнэлнэ
- 4.3.4 Ажлын хэсэг нь оролцох саналын үнэлгээг хийхдээ “Сонгон шалгаруулалтын журам”-ыг дагаж мөрдөнө
- 4.3.5 оролцох саналын иж бүрдэл бүрэн эсэх, зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлсэн эсэх, оролцох санал гаргагчдад тавих ерөнхий шаардлагыг хангаж байгаа эсэхийг шалгаж, “шаардлага хангасан/шаардлага хангаагүй” гэсэн үнэлгээ тавина. Зөвхөн “шаардлага хангасан” үнэлгээ авсан оролцох саналд санхүүгийн чадавхын болон техник, технологийн чадварын үнэлгээ хийнэ. “Шаардлага хангаагүй” үнэлгээ авсан оролцох саналыг урьдчилсан шалгаруулалтад тэнцээгүйд тооцно.
- 4.3.6 санхүүгийн чадавх, техник, технологийн чадварыг оноогоор үнэлнэ. Шалгуур үзүүлэлт, дэд үзүүлэлт тус бүрээр оноо тавьж, авсан оноонуудыг жигнэн нэгтгэх замаар 100 онооноос авах дундаж оноог тооцож гаргана. Урьдчилсан шалгаруулалтад тэнцэхийн тулд хамгийн багадаа 60 оноо авсан байх шаардлагатай.

Үнэлгээний аргачлалын тоймыг доорх хүснэгтээр үзүүлэв.

Шалгуур үзүүлэлтүүд	Дэд үзүүлэлтүүд	Харгалзах маягт	Жин (хувь)
Санхүүгийн чадавх	Санхүүгийн чадавх	Маягт 4	(хувь)
	Шаардагдах санхүүжилтийг бүрдүүлэх чадавх	Маягт 5	(хувь)
	Нийлбэр		
Техник, технологийн чадвар	Зураг төслийн ажлын туршлага	Маягт 6	(хувь)
	Барилгын ажлын туршлага	Маягт 7	
	Ашиглалтын үйл ажиллагааны туршлага	Маягт 8	
	Түншлэлийн төсөл хэрэгжүүлж байсан туршлага	Маягт 9	(хувь)
	ижил төстэй төсөл хэрэгжүүлсэн туршлага	Маягт 10	(хувь)
	Санал гаргагчийн бүтэц, зохион байгуулалт	Маягт 11	(хувь)
	Техник хэрэгсэл	Маягт 12	(хувь)
	Удирдлага, хүний нөөцийн чадавх		

	Нийлбэр		
Нийт			100

*/Санхүүгийн чадавхын үнэлгээний нийт оноонд эзлэх жин 20-50 хувь байх бөгөөд тухайн төслийн онцлогийг харгалзан уралдаант шалгаруулалтын комисс тогтооно.*

*Техник, технологийн чадварын үнэлгээний нийт оноонд эзлэх жин 50-80 хувь байх бөгөөд тухайн төслийн онцлогийг харгалзан уралдаант шалгаруулалтын комисс тогтооно./*

- 4.3.7 Ажлын хэсэг энэхүү урьдчилсан шалгаруулалтын баримт бичигт тусгасан шалгуур үзүүлэлтүүдийг хамгийн сайн хангаж 60 буюу түүнээс дээш оноо авсан нийт [тоо] хүртэлх оролцох санал гаргагчаар хязгаарлан уралдаант шалгаруулалтад орох оролцогчдын хураангуй жагсаалтыг гаргана.
- 4.3.8 Урьдчилсан шалгаруулалтын үнэлгээг хийж дуусмагц бүх оролцох санал гаргагчид тухайн оролцох санал гаргагч урьдчилсан шалгаруулалтад тэнцсэн эсэх тухай бичгээр мэдэгдэнэ.

## **5 Оролцох саналын жишиг маягтууд**

### Маягт 1-Оролцох саналын мэдүүлэг

Огноо:

Хэнд: [Уралдаант шалгаруулалтын ажлын хэсгийн нарийн бичгийн даргын хаяг] [Төслийн нэр] төслийн урьдчилсан шалгаруулалтад оролцох санал

Бид тус төслийн урьдчилсан шалгаруулалтад оролцохоор урьдчилсан шалгаруулалтын баримт бичигт заасны дагуу шаардлагатай маягтуудыг туршлагын талаарх мэдээллийн хамт үүгээр хүргүүлж байна.

а) Бид урьдчилсан шалгаруулалтын баримт бичгийг судалж, бүрэн ойлгосон болно. б) Бид [гишүүн компаниудын хамтаар] энэхүү урьдчилсан шалгаруулалтын оролцох санал гаргагчдад тавих ерөнхий шаардлагыг хангасан болно.

Хэрвээ бид урьдчилсан шалгаруулалтаар тэнцэж, оролцогчдын жагсаалтад орвол уралдаант шалгаруулалтад оролцон, төслийн саналаа уралдаант шалгаруулалтын баримт бичгийн дагуу бэлтгэж хүргүүлнэ гэдгийг үүгээр баталж байна.

Нэр

Албан тушаал

Гарын үсэг

[Оролцох санал гаргагчийн нэр, хаяг]

*/Энэхүү мэдүүлгийг гишүүн компаниудын итгэмжлэгдсэн төлөөлөгч, эсхүл хуулийн этгээд дангаараа оролцох санал гаргасан бол тухайн хуулийн этгээд бөглөнө./*

**Маягт 2-Оролцох санал гаргагчийн мэдээллийн хүснэгт**

<b>Оролцох санал гаргагчийн мэдээлэл</b>	
Албан ёсны нэр	
Түншлэлийн хувьд гишүүдийн албан ёсны нэр	
Үүсгэн байгуулагдсан эсхүл үүсгэн байгуулагдахаар төлөвлөсөн улс	
Үүсгэн байгуулагдсан эсхүл үүсгэн байгуулагдахаар төлөвлөсөн он	
Үүсгэн байгуулагдсан улс дахь албан ёсны хаяг	
Оролцох санал гаргагчийг төлөөлөх эрх бүхий этгээд (нэр, албан тушаал, хаяг, утасны дугаар, факсын дугаар, и-мэйл)	
<p>Дараах баримт бичгийн хуулбарыг хавсаргав. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"><li>1. Оролцох санал гаргагч нь нэг хуулийн этгээд бол хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар эсхүл үүсгэн байгуулагдсаныг нотлох түүнтэй адилтгах бусад баримт бичиг</li><li>2. Оролцох санал гаргагч эсхүл түншлэлийг төлөөлөх эрх олгосон этгээдийн итгэмжлэл</li><li>3. Түншлэлийн хувьд талууд хамтран ажиллахаа илэрхийлсэн хамтран ажиллах гэрээний хуулбар</li></ol>	

*/Энэхүү хүснэгтийг гишүүн компаниудын итгэмжлэгдсэн төлөөлөгч эсхүл хуулийн этгээд дангаараа оролцох санал гаргасан бол тухайн хуулийн этгээд бөглөнө./*

**Маягт 3-Гишүүн компаниудын мэдээллийн хүснэгт**

<b>Түншлэлийн гишүүний мэдээлэл</b>	
Оролцох санал гаргагчийн албан ёсны нэр	
Түншлэлийн гишүүний албан ёсны нэр	

Түншлэлийн гишүүний үүсгэн байгуулагдсан улс	
Түншлэлийн гишүүний үүсгэн байгуулагдсан он	
Түншлэлийн гишүүний үүсгэн байгуулагдсан улс дахь албан ёсны хаяг	
Түншлэлийн гишүүдийг төлөөлөх эрх бүхий этгээд (нэр, албан тушаал, хаяг, утасны дугаар, факсын дугаар, и-мэйл)	
<p>Дараах баримт бичгийн хуулбарыг хавсаргав. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар эсхүл үүсгэн байгуулагдсаныг нотлох түүнтэй адилтгах бусад баримт бичиг</li> <li>2. Түншлэлийн гишүүнийг төлөөлөх эрх олгосон этгээдийн итгэмжлэл</li> </ol>	

*/Энэхүү хүснэгтийг оролцох санал гаргагчид нээгдэл болон оролцож байгаа үед гишүүн компани бүр бөглөнө./*

**Маягт 4-Санхүүгийн чадавх**

Санхүүгийн үзүүлэлт	Өмнөх жилүүдийн санхүүгийн үзүүлэлт [төгрөг]				
	Он 1:	Он 2:	Он 3:	Дундаж	Дундаж харьцаа
Балансын мэдээлэл					
Нийт хөрөнгө (НХ)					НХ/НӨ
Нийт өр төлбөр (НӨ)					
Цэвэр хөрөнгө (ЦХ)					
Эргэлтийн					ЭХ/БӨ

хөрөнгө (ЭХ)					
Богино хугацаат өр төлбөр (БӨ)					

Орлогын тайлангийн мэдээлэл					
Нийт борлуулалт (НБ) [= 2 – 4]					НБ/ТӨА
Татварын өмнөх ашиг (ТӨА) [өмнөх жилийн = 5 / 7]					
<p>Дараах баримт бичгийн хуулбарыг хавсаргав.</p> <p>Сүүлийн 3 жилийн аудит хийсэн санхүүгийн тайлан (баланс, орлогын тайлан, холбогдох тодруулгын хамт)</p>					

*/Энэхүү хүснэгтийг гишүүн компаниудын итгэмжлэгдсэн төлөөлөгч эсхүл хуулийн этгээд дангаараа оролцох санал гаргасан бол тухайн хуулийн этгээд бөглөнө./*

#### Маягт 5-Шаардагдах санхүүжилтийг бүрдүүлэх чадавх

##### 5.1. Санхүүжилтийн ерөнхий төлөвлөгөө

[Төслийн санхүүжилтийн төлөвлөгөөний талаарх санал]

##### 5.2. Санхүүжилт бүрдүүлэх чадавх

[Өмнө нь төслийн санхүүжилт бүрдүүлж байсан туршлага, санхүүжилтийн хэмжээ, хэлбэр, тухайн төсөлд гүйцэтгэсэн үүргийнхээ талаар мэдээлэл]

5.3. Өөрийн хөрөнгийн эх үүсвэр [Түншлэлд хөрөнгө оруулагчаар оролцож байгаа бол оруулж байгаа хөрөнгийн эх үүсвэрээ дурдана уу (жишээ нь: мөнгөн хөрөнгө, ирээдүйд олох орлого, толгой компанийн дэмжлэг гэх мэт)

#### Маягт 6-Зураг төслийн ажлын туршлага

Хүснэгтэд сүүлийн 5 жилийн зураг төслийн ажлын туршлагаа дурдана уу.

**Компанийн нэр:**

Төслийн нэр, барьсан байгууламжийн төрөл	Гүйцэтгэсэн үүрэг (гол гэрээлэгч, туслан гүйцэтгэгч)	Захиалагчийн нэр, хаяг	Зураг төслийг боловсруулсан хугацаа	Төслийн одоогийн байдал (тайлбар)
[Тухайн төслийн мэдээлэл]				
[Тухайн төслийн мэдээлэл]				
<p>Төслийн одоогийн байдлыг харуулах Дараах нэмэлт мэдээллийг хавсаргав. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Төслийн үйл ажиллагаа, байгаа байдлыг харуулсан зураг</li> <li>2. Захиалагчаас ирүүлсэн тодорхойлолт, санал</li> </ol>				

*/Энэхүү хүснэгтийг гишүүн компаниудын итгэмжлэгдсэн төлөөлөгч эсхүл хуулийн этгээд дангаараа оролцох санал гаргасан бол тухайн хуулийн этгээд бөглөнө./*

**Маягт 7-Барилгын ажлын туршлага**

Хүснэгтэд сүүлийн 5 жилийн барилгын ажлын туршлагаа дурдана уу.

**Компанийн нэр:**

Төслийн нэр, барьсан байгууламжийн төрөл	Гүйцэтгэсэн үүрэг (гол гэрээлэгч, туслан гүйцэтгэгч)	Захиалагчийн нэр, хаяг	Гэрээний үнийн дүн (сая төгрөг)	Эхлэх, дуусах хугацаа	Төслийн одоогийн байдал (тайлбар)
[Тухайн төслийн мэдээлэл]					
[Тухайн төслийн мэдээлэл]					
<p>Төслийн одоогийн байдлыг харуулах Дараах нэмэлт мэдээллийг хавсаргав. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Төслийн үйл ажиллагаа, байгаа байдлыг харуулсан зураг</li> <li>2. Захиалагчаас ирүүлсэн тодорхойлолт, санал</li> </ol>					

*/Энэхүү хүснэгтийг гишүүн компаниудын итгэмжлэгдсэн төлөөлөгч эсхүл хуулийн этгээд дангаараа оролцох санал гаргасан бол тухайн хуулийн этгээд бөглөнө./*

**Маягт 8-Ашиглалтын үйл ажиллагааны туршлага**

Хүснэгтэд сүүлийн 5 жилд гүйцэтгэсэн төслийн ашиглалтын үйл ажиллагааны туршлагаа дурдана уу.



Компанийн нэр:

Төслийн нэр, байгууламжийн төрөл	Гүйцэтгэсэн үүрэг, үзүүлсэн үйлчилгээ (ямар төрлийн байгууламжийн ашиглалтын үйл ажиллагааг гүйцэтгэсэн, тус байгууламжаар үзүүлсэн үйлчилгээний төрөл)	Захиалагчийн нэр, хаяг	Ашиглалтын үйл ажиллагааг хариуцан явуулсан байгууламжийн жилийн борлуулалтын хэмжээ	Ашиглалтын үйл ажиллагааны гэрээний хугацаа	Төслийн одоогийн байдал (тайлбар)
[Тухайн төслийн мэдээлэл]					
[Тухайн төслийн мэдээлэл]					
<p>Төслийн одоогийн байдлыг харуулах Дараах нэмэлт мэдээллийг хавсаргав. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Төслийн үйл ажиллагаа, байгаа байдлыг харуулсан зураг</li> <li>2. Захиалагчаас ирүүлсэн тодорхойлолт, санал</li> </ol>					

*/Энэхүү хүснэгтийг гишүүн компаниудын итгэмжлэгдсэн төлөөлөгч эсхүл хуулийн этгээд дангаараа оролцох санал гаргасан бол тухайн хуулийн этгээд бөглөнө./*

**Маягт 9-Оролцох санал гаргагчийн бүтэц, зохион байгуулалт**

**9.1. Түншлэлийн гишүүдийн оролцоо**

[Түншлэлийн гишүүн тус бүрийн үүрэг, хөрөнгө оруулагчдын оролцох оролцооны хувийг тодорхой бичнэ үү] Гишүүний нэр Үүрэг Хувь нийлүүлэх эсэх? Нийлүүлэх хувь Тийм/Үгүй

**9.2 Бүтэц, зохион байгуулалт, ажлын хуваарь**

[Түншлэл болон үүсгэн байгуулагдах төслийн компанийн зохион байгуулалтын бүтцийг танилцуулна уу. Түншлэлийн гишүүд хоорондын (хэрэв нэгээс их бол) ажил үүргийн хуваарь, мөн энэ нь төслийн уралдаант шалгаруулалт, барилгын ажил, ашиглалтын үйл ажиллагааны шатанд өөрчлөгдөх эсэхийг тодорхой дурдана уу]

**9.3. Түншлэлийн гишүүдийн хоорондох харилцаа [Түншлэлийн гишүүдийн хооронд өмнө байсан буюу одоо байгаа ажил хэргийн харилцааг дэлгэрэнгүй дурдана уу]**

*/Энэхүү мэдүүлгийг гишүүн компаниудын итгэмжлэгдсэн төлөөлөгч эсхүл хуулийн этгээд дангаараа оролцох санал гаргасан бол тухайн хуулийн этгээд бөглөнө./*

### Маягт 10-Техник хэрэгсэл

(Төслийг хэрэгжүүлэхэд санал болгож байгаа барилгын үндсэн машин механизм, тоног төхөөрөмжийн нэр төрлийн талаарх мэдээллийг доорх хүснэгтээр ирүүлнэ үү)

Тоног төхөөрөмжийн нэр төрөл	Тодорхойлолт, үйлдвэрлэгдсэн, ашиглагдсан (жилээр)	хаана хугацаа	Ашиглалтын байдал (шинэ, сайн, хуучин), тоо ширхэг	Өөрийн, түрээслэх, худалдаж (хаанаас) эсхүл авах

Дараах нэмэлт мэдээллийг хавсаргав.

1. Төслийг хэрэгжүүлэхэд санал болгож байгаа технологийн шийдлийг танилцуулгын хамт

*/Энэхүү хүснэгтийг гишүүн компаниудын итгэмжлэгдсэн төлөөлөгч эсхүл хуулийн этгээд дангаараа оролцох санал гаргасан бол тухайн хуулийн этгээд бөглөнө./*

### Маягт 11-Удирдлага, хүний нөөцийн чадавх

(Төслийг хэрэгжүүлэхэд санал болгож байгаа удирдах болон техникийн голлох мэргэжилтний чадвар, туршлагыг бичих)

Албан тушаал	Нэр	Ажилласан жил(нийт)	Санал болгож байгаа албан тушаалтай ижил албан тушаалд ажилласан жил

Дараах баримт бичгийн хуулбарыг хавсаргав.

1. Удирдах болон техникийн голлох мэргэжилтнүүдийн анкет, мэргэшлийн зэргийн үнэмлэхийн хуулбар

*/Энэхүү хүснэгтийг гишүүн компаниудын итгэмжлэгдсэн төлөөлөгч эсхүл хуулийн этгээд дангаараа оролцох санал гаргасан бол тухайн хуулийн этгээд бөглөнө./*

### Маягт: Түншлэлийн төсөл хэрэгжүүлж байсан туршлага, ижил төстэй төсөл хэрэгжүүлсэн туршлага

Төслийн нэр, байгууламжийн төрөл	Түншлэлийн гэрээний төрөл, үзүүлсэн үйлчилгээ	Захиалагч ийн нэр, хаяг	Түншлэлийн төрөл, жилийн орлого, зардлын хэмжээ	Түншлэлийн гэрээний хугацаа	Төслийн одоогийн байдал (тайлбар)
[Тухайн төслийн мэдээлэл]					
[Тухайн төслийн мэдээлэл]					
<p>Төслийн одоогийн байдлыг харуулах Дараах нэмэлт мэдээллийг хавсаргав. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Төслийн хэрэгжилтийн тайлан</li> <li>2. Захиалагчаас ирүүлсэн тодорхойлолт, санал</li> </ol>					

*/Энэхүү хүснэгтийг гишүүн компаниудын итгэмжлэгдсэн төлөөлөгч эсхүл хуулийн этгээд дангаараа оролцох санал гаргасан бол тухайн хуулийн этгээд бөглөнө./*

---o0o---

Төсөл

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны  
... дүгээр тогтоолын гуравдугаар хавсралт

## II. ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭГЧ СОНГОХ УРАЛДААНТ ШАЛГАРУУЛАЛТЫН ЖИШИГ БАРИМТ БИЧИГ

[ТӨСЛИЙН НЭР] ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭГЧ СОНГОХ УРАЛДААНТ  
ШАЛГАРУУЛАЛТЫН БАРИМТ БИЧИГ

Огноо:

Дугаар:

## **САНАМЖ**

Төр, хувийн хэвшлийн тухай хуулийн дагуу хувийн хэвшлийн түншлэгчийг сонгон шалгаруулалтын уралдаант шалгаруулалтын үе шатыг зохион байгуулахад энэ жишиг баримт бичгийг баримтална.

Энэхүү жишиг баримт бичгийн дагуу төсөл хэрэгжүүлэх санал боловсруулах, уралдаант сонгон шалгаруулалтын баримт бичгийг боловсруулах бөгөөд зөвхөн урьдчилсан шалгаруулалтын шатанд тэнцсэн хураангуй жагсаалтын оролцогчдод олгоно.

Энэхүү тендерийн жишиг баримт бичгийн санамж болон бүлэг, зүйлийн оноосон нэр нь зөвхөн уг баримт бичгийг ойлгоход хялбар болгох зорилготой.

## ГАРЧИГ

1	Ерөнхий мэдээлэл .....	6
1.1	Уралдаант шалгаруулалтын баримт бичгийн зорилго .....	6
1.2	Нэр томъёоны тайлбар .....	6
1.3	Түншлэлийн төслийн танилцуулга.....	8
1.4	Төрийн түншлэгч .....	8
1.5	Зохицуулах байгууллага .....	8
2	Түншлэлийн төслийн мэдээлэл .....	8
2.1	Төслийн үндэслэл .....	8
2.2	Төслийн цар хүрээ .....	8
2.3	Төслийн байршил, газар.....	8
2.4	Байгаль орчин, эрүүл ахуй, хөдөлмөрийн аюулгүй байдал, ажиллах хүч .....	9
2.5	Шаардлагатай зөвшөөрөл, тусгай зөвшөөрөл .....	9
2.6	Техникийн тодорхойлолт .....	9
3	Оролцогчид өгөх заавар.....	9
3.1	Танилцуулга .....	9
3.2	Оролцогчид тавих шаардлага .....	9
3.3	Албан ёсны хэл .....	10
3.4	Оролцогч тодруулга хүсэх .....	10
3.5	Үнэлгээний өмнөх уулзалт.....	10
3.6	Уралдаант шалгаруулалтын баримт бичгийг хүчингүй болгох, нэмэлт, өөрчлөлт оруулах.....	11
3.7	Төслийн санал.....	11
3.8	Техникийн санал бэлтгэх.....	12
3.9	Санхүүгийн санал бэлтгэх .....	13
3.10	Төслийн баталгааны шаардлага .....	15
3.11	Төслийн саналын битүүмжлэл, тэмдэглэгээ .....	16
3.12	Төслийн санал хүчинтэй байх хугацаа .....	16
3.13	Төслийн санал хүлээн авах.....	17
3.14	Нууцлал.....	17
3.15	Ажлын хэсэг тодруулга хүсэх.....	17
4	Төслийн саналын үнэлгээ .....	17
4.1	Үнэлгээний дараалал.....	17

4.2	Төслийн саналаас татгалзах эрх .....	17
4.3	Техникийн саналын үнэлгээ .....	18
4.4	Санхүүгийн саналын үнэлгээ .....	18
4.5	Түншлэлийн гэрээ байгуулах .....	19
4.6	Түншлэлийн гэрээг байгуулах зардал болон эрсдэл.....	19
5	Түншлэлийн гэрээ.....	19
5.1	Танилцуулга .....	19
5.2	Түншлэлийн гэрээ .....	20
5.3	Нэмэлт гэрээ .....	20
6	Хавсралтууд.....	20
6.1	Төслийн саналын маягт .....	20
6.2	Түншлэлийн гэрээний төсөл.....	25



# 1 Ерөнхий мэдээлэл

## 1.1 Уралдаант шалгаруулалтын баримт бичгийн зорилго

Энэхүү уралдаант шалгаруулалтын баримт бичигт [төслийн нэр] ерөнхий мэдээлэл, түншлэлийн төслийн дэлгэрэнгүй мэдээлэл, оролцогчид өгөх зааварчилгаа, төслийн саналын үнэлгээ, түншлэлийн гэрээний төсөл болон төслийн саналын маягтуудыг багтаасан болно. Ажлын хэсэг оролцогчийн ирүүлсэн төслийн саналыг сонгон шалгаруулалтын журмын дагуу үнэлж, шалгарсан оролцогчдын жагсаалт гаргахад энэхүү уралдаант шалгаруулалтын баримт бичгийг ашиглана.

## 1.2 Нэр томъёоны тайлбар

- 1.2.1 “гишүүн компани” гэж хувийн хэвшлийн түншлэгчийг бүрдүүлж буй түүнд орсон хуулийн этгээдийг;
- 1.2.2 “зохицуулах байгууллага” гэж түншлэлийг хэрэгжүүлэхэд шаардлагатай зөвшөөрөл, тусгай зөвшөөрөл олгох, үнэ тариф тогтоох, түншлэлийн зүйл эсхүл түүгээр үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон дүрэм, журмыг батлах, мөрдүүлэх үүрэг бүхий төрийн байгууллагыг;
- 1.2.3 "төр, хувийн хэвшлийн түншлэл" гэж хувийн хэвшлийн түншлэгч нь төрийн түншлэгчтэй байгуулсан түншлэлийн гэрээний дагуу нийтийн зориулалттай дэд бүтэц, төрийн үйлчилгээг олон нийтэд, төрийн түншлэгчид урт хугацаанд үзүүлэх, түншлэгч талууд эрсдэлийг оновчтой хуваарилах, түншлэлийн төлбөрийг түншлэлийн төрлөөс хамаарч санхүүжүүлэн хэрэгжүүлэх замаар төслийг урт хугацаанд тогтвортой, үр ашигтай хэрэгжүүлэх хамтын ажиллагааг;
- 1.2.4 “түншлэлийн зүйл” гэж түншлэлийн гэрээнд хамаарах эд хөрөнгийн эрх, ажил, үйлчилгээний үр дүн, хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгийг;
- 1.2.5 “түншлэлийн гэрээ” гэж төрийн болон хувийн хэвшлийн түншлэгч талуудын хооронд түншлэлийн төслийг хэрэгжүүлэхээр харилцан тохиролцож, талуудын эрх, үүрэг болон холбогдох бусад асуудлыг тодорхойлж байгуулсан иргэний эрх зүйн гэрээг;
- 1.2.6 "төрийн түншлэгч" гэж түншлэлийн гэрээг хэрэгжүүлэх тухайн салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон түншлэлийн гэрээнд заасны дагуу энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан бусад этгээдийг
- 1.2.7 "хувийн хэвшлийн түншлэгч" гэж төрийн түншлэгчтэй түншлэлийн гэрээ байгуулж, энэ хуульд заасан түншлэлийн төслийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Компанийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын тухай хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан гадаад, дотоодын хөрөнгө оруулалттай хуулийн этгээд болон хуулийн этгээдийн нэгдлийг;
- 1.2.8 "санхүүжүүлэгч" гэж хувийн хэвшлийн түншлэгчид төсөл хэрэгжүүлэхтэй холбогдуулан зээл олгож байгаа болон түншлэлийн төсөлд санхүүгийн баталгаа гаргах, санхүүгийн бусад дэмжлэг үзүүлж байгаа хувьцаа эзэмшигчээс бусад банк, санхүүгийн байгууллагыг;

- 1.2.9 “оролцогч” гэж урьдчилсан шалгаруулалтад тэнцсэн хураангуй жагсаалтад орсон этгээдийг;
- 1.2.10 “төслийн санал” гэж оролцогчдоос уралдаант шалгаруулалтын баримт бичгийн дагуу ирүүлсэн саналыг;
- 1.2.11 "тусгай зориулалтын компани" гэж түншлэлийн гэрээний хүрээнд хувийн хэвшлийн түншлэгчийн үүргийг хүлээж, түншлэлийн төслийг хэрэгжүүлэх тусгай зориулалтаар хувийн хэвшлийн түншлэгчээс үүсгэн байгуулсан төслийн компанийг;
- 1.2.12 “сонгон шалгаруулалтын ажлын хэсэг” гэж Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 24.1-т заасан ажлын хэсгийг;
- 1.2.13 “урьдчилсан шалгаруулалт” гэж Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 25.1-ээс 25.5 дах хэсэгт заасан сонгон шалгаруулалтын үе шатыг
- 1.2.14 “урьдчилсан шалгаруулалтын баримт бичиг” гэж Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 25.2.2-т заасан шалгуур үзүүлэлтүүд, шаардлагатай бусад мэдээллийг тусгасан баримт бичгийг;
- 1.2.15 “уралдаант шалгаруулалт” гэж Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 25 дугаар зүйлд заасан сонгон шалгаруулах үйл ажиллагааг;
- 1.2.16 “уралдаант шалгаруулалтын хуваарь” гэж уралдаант шалгаруулалтын нарийвчилсан төлөвлөгөөг;
- 1.2.17 “уралдаант шалгаруулалтын баримт бичиг” гэж оролцогчдод олгох Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 25.6.2-д заасан шалгуур үзүүлэлтүүд, шаардлагатай бусад мэдээллийг тусгасан баримт бичгийг;
- 1.2.18 "мөнгөний үнэ цэнэ" гэж түншлэлийн төслийн хэрэгжилтийн бүх үе шатанд төслийн нийт өртгөөр төслийн үйлчилгээг чанар, хүртээмж, үр ашиг, өгөөжтэй байх хувилбарыг тогтоохыг;
- 1.2.19 "санхүүгийн чадавхад нийцсэн" гэж түншлэлийн хүрээнд үзүүлж байгаа үйлчилгээнд хэрэглэгчээс авах хураамж, төсвөөс санхүүжүүлэх санхүүжилт нь хэрэглэгчийн болон төсвийн чадавхад нийцсэн байх, төсвийн хувьд зардал болон болзошгүй өр төлбөрийг орлогоос шийдвэрлэх боломжтой байхыг;
- 1.2.20 "төсөвт үзүүлэх нөлөө" гэж төслийг хэрэгжүүлэхэд төсөв, санхүүд үзүүлэх нөлөөллийг тооцох, шууд болон шууд бус байдлаар төлбөрийн үүрэг хариуцлагыг бий болгох болзошгүй нөхцөл байдлыг;
- 1.2.21 "төслийн орлого" гэж хэрэглэгчийн төлбөр, хураамж болон түншлэлийн гэрээний хүрээнд бий болсон төслийн орлогын эх үүсвэрийг;
- 1.2.22 "түншлэлийн зүйл" гэж түншлэлийн гэрээнд хамаарах эд хөрөнгийн эрх, ажил, үйлчилгээний үр дүн, хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгийг;

1.2.23 "түншлэлийн төсөл" гэж нийтийн зориулалттай дэд бүтэц, төрийн үйлчилгээний салбарт нийтийн хэрэгцээ, шаардлагыг хангах зорилгоор хувийн хэвшлийн түншлэгч хөрөнгө оруулалт хийх, зураг төсөл боловсруулах, дэд бүтцийн барилга, байгууламжийг барих, санхүүжүүлэх, сэргээн босгох, сайжруулах, засвар арчлалт хийх, төрийн үйлчилгээг үзүүлэх, төрийн үйлчилгээний удирдлагыг хариуцах зэрэг үйл ажиллагааг багтаасан нийтэд чиглэсэн төслийг;

### 1.3 Түншлэлийн төслийн танилцуулга

[Төслийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаргасан хууль тогтоомж, бодлого, шийдвэр, барилгын ажлыг гүйцэтгэх хугацаа, төсөвлөсөн нийт өртөг гэх мэт мэдээллийг дэлгэрэнгүй оруулах]

### 1.4 Төрийн түншлэгч

[Төслийн нэр]-ийг хэрэгжүүлэх төрийн түншлэгч нь [байгууллагын нэр] байна. [Байгууллагын танилцуулга, хуулиар олгогдсон эрх, үүргийн талаар танилцуулга, тайлбар]

### 1.5 Зохицуулах байгууллага

[Төслийн нэр]-ийн зохицуулах байгууллагад дараах байгууллагууд орно:

[Зохицуулах байгууллагын нэр]

[Зохицуулах байгууллагын төсөлд гүйцэтгэх үүрэг, түүний хууль эрх зүйн байдлыг бичих]

## 2 Түншлэлийн төслийн мэдээлэл

### 2.1 Төслийн үндэслэл

[Төслийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаргасан хууль, төрөөс баримталж байгаа бодлого, шийдвэр гэх мэт мэдээллийг дэлгэрэнгүй оруулах]

### 2.2 Төслийн цар хүрээ

Хувийн хэвшлийн түншлэгч нь [төслийн нэр] түншлэлийн төслийг [Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлд заасан түншлэлийн гэрээний төрөл] хэлбэрээр хэрэгжүүлж [төслийн хүрээнд хийгдэх зураг төсөл, барилгын ажил, хөрөнгө оруулалт, ашиглалтын үйл ажиллагаа, засвар арчлалтын гэх мэт ажлуудыг тодорхойлж бичих] ажлуудыг гүйцэтгэнэ.

Хувийн хэвшлийн түншлэгчийн үйл ажиллагааны үндсэн чиглэл нь түншлэлийн зүйлийн [зураг төсөл боловсруулах, санхүүжүүлэх, барих, ашиглах болон засварлах гэх мэт батлагдсан түншлэлийн төрлийн дагуу тохирох үйл ажиллагаа] үйл ажиллагаа байх бөгөөд эдгээрийг түншлэлийн гэрээ болон уралдаант шалгаруулалтын баримт бичигт дурдсан бусад нэмэлт гэрээнүүдэд нарийвчлан тусгана. Хувийн хэвшлийн түншлэгч нь үйл ажиллагааныхаа үндсэн чиглэлийг өөрчлөхгүй.

### 2.3 Төслийн байршил, газар

Энэхүү түншлэлийн төсөл хэрэгжих байршил нь [харьяалагдах засаг захиргааны нэгж]-ийн нутаг дэвсгэр [байрлал, байршил зүйн бусад тодорхойлолт]-т байршилтай байна.

Төслийн газрыг хувийн хэвшлийн түншлэгчид [төсөл хэрэгжүүлж эхлэх өдөр] өдрөөс эхлэн [түншлэлийн гэрээний хугацаа] хугацаатай Газрын тухай хуульд заасан нөхцөлөөр олгоно.

#### 2.4 Байгаль орчин, эрүүл ахуй, хөдөлмөрийн аюулгүй байдал, ажиллах хүч

[Төсөл хэрэгжүүлэхтэй холбогдуулан хувийн хэвшлийн түншлэгчийн дагаж мөрдөх шаардлагатай байгаль орчин, эрүүл ахуй, хөдөлмөрийн аюулгүй байдал, ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хууль тогтоомж, стандартын шаардлагуудыг бичих]

#### 2.5 Шаардлагатай зөвшөөрөл, тусгай зөвшөөрөл

Хувийн хэвшлийн түншлэгч төсөл хэрэгжүүлэхтэй холбоотойгоор шаардагдах зөвшөөрөл болон тусгай зөвшөөрлийг авах, холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн ажиллах үүрэг хүлээнэ. Төрийн түншлэгч, зохицуулах байгууллага нь хувийн хэвшлийн түншлэгчид шаардлагатай тохиолдолд зөвшөөрөл авахад нь хууль тогтоомжийн хүрээнд дэмжлэг үзүүлж, төслийн ажлыг саадгүй явуулахад анхаарал тавьж ажиллана.

#### 2.6 Техникийн тодорхойлолт

Төслийн техникийн шаардлага, дэд бүтцийн мэдээлэл, төлөвлөлт, дизайн, хүлээгдэж буй үр дүн, барилга угсралт, үйл ажиллагаа, ашиглалтын үеийн шаардлага тодорхойлолт, чанарын стандарт, үйлчилгээний шалгуур үзүүлэлт, техник технологийн шалгуур үзүүлэлтүүд,

### 3 Оролцогчид өгөх заавар

#### 3.1 Танилцуулга

Сонгон шалгаруулалтын ажлын хэсэг (цаашид “ажлын хэсэг” гэх) нь Засгийн газрын 2023 оны ХХ дугаар тогтоолоор батлагдсан “Хувийн хэвшлийн түншлэгчийг болон зөвлөх үйлчилгээг сонгон шалгаруулах журам”-ыг баримтална. Уралдаант шалгаруулалтыг дараах хуваарийн дагуу явуулна.\*

Агуулга	Огноо:
Уралдаант шалгаруулалтын баримт бичиг олгож эхлэх	[огноо]
Төслийн санал хүлээн авах эцсийн хугацаа	[огноо] цагаас өмнө
Дараалуулсан жагсаалт гаргах	[огноо]
Түншлэлийн гэрээнд гарын үсэг зурах	[огноо]

*\*Ажлын хэсэг уралдаант шалгаруулалтын хуваарьт өөрчлөлт оруулж болох бөгөөд уг өөрчлөлтөө түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар батлуулна.*

#### 3.2 Оролцогчид тавих шаардлага

Оролцогч нь урьдчилсан шалгаруулалтын үед тавигдсан ерөнхий шаардлага болон чадварын шалгуурыг уралдаант шалгаруулалтын үед үргэлжлүүлэн хангах бөгөөд үүнтэй холбогдуулан ямар нэгэн өөрчлөлт гарсан тохиолдолд 5 /таван/ өдрийн дотор ажлын хэсэгт мэдэгдэх үүрэгтэй. Ажлын хэсэг тухайн өөрчлөлт нь оролцогчийг ерөнхий шаардлага болон чадварын шалгуурыг хангаж байгаа эсэхийг нягтлан, оролцогч тухайн өөрчлөлтийн талаар 5 /таван/ өдрийн дотор

уралдаант шалгаруулалтын ажлын хэсэгт мэдэгдээгүй эсхүл нуун дарагдуулсан нь илэрсэн тохиолдолд уралдаант шалгаруулалтаас хасах үндэслэл болно.

Оролцогч нь төслийн санал ирүүлэхдээ ажлын хэсгийн зөвшөөрлийг урьдчилан авахгүйгээр гишүүн компаниудын бүтэц, зохион байгуулалтыг өөрчилсөн эсхүл гишүүн нь өөр оролцогчийн гишүүн компаниар төслийн санал ирүүлсэн байх нь уралдаант шалгаруулалтаас хасах үндэслэл болно.

Оролцогчоос уралдаант шалгаруулалтын үед хуурамч мэдээлэл, баримт нотолгоо ирүүлсэн нь илэрсэн тохиолдолд эрх бүхий этгээд төслийн саналд үндэслэн байгуулсан аливаа гэрээ, хэлэлцээрийг цуцлах эрхтэй бөгөөд гэрээ, хэлэлцээрийг цуцалснаас учирсан хохирлыг оролцогч өөрөө хариуцна.

### 3.3 Албан ёсны хэл

Уралдаант шалгаруулалттай холбоотой аливаа харилцааг [монгол эсхүл англи] хэлээр явуулна. Төслийн саналын иж бүрдлийг [монгол эсхүл англи] хэлээр бэлтгэж ирүүлнэ.

### 3.4 Оролцогч тодруулга хүсэх

Оролцогч уралдаант шалгаруулалттай холбоотой аливаа тодруулга авах хүсэлтийг доорх хаягийн дагуу албан бичгээр гаргаж болно.

[ажлын хэсгийн нарийн бичгийн даргын хаяг, холбоо барих мэдээлэл]

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга нь тодруулга хүссэн албан бичгийг Түншлэлийн төвийн бичиг хэргээр дамжуулан хүлээн авах бөгөөд ажлын хэсгийн даргад танилцуулна. Ажлын хэсгийн дарга тодруулга өгөх ажлыг зохион байгуулна. Тодруулгыг хүсэлт гаргасан этгээдийг дурдалгүйгээр бүх оролцогчид зэрэг явуулна. Тодруулга авах хүсэлтийг төслийн санал хүлээн авах эцсийн хугацаанаас 10 /арван/ өдрийн өмнө ирүүлэх бөгөөд хоцорч ирсэн хүсэлтэд хариу өгөхгүй.

### 3.5 Үнэлгээний өмнөх уулзалт

Ажлын хэсэг нь үнэлгээний өмнөх уулзалтыг [огноо] өдрийн [цаг]-т [уулзалт хийх газар]-т зохион байгуулна. [Үнэлгээний өмнө төслийн байршилтай танилцах ажлыг уг уулзалтын нэг хэсэг болгож зохион байгуулна.] [Үнэлгээний өмнөх уулзалт болон төслийн талбайтай танилцахад нийт оролцогчийн тооноос хамааран төлөөлөгчийн тоог хязгаарлаж болох бөгөөд гадаад орны оролцогч нэг орчуулагчтай оролцож болно. Оролцогч нь уулзалтаас нэг долоо хоногийн өмнө оролцох тухайгаа ажлын хэсэгт мэдэгдэх бөгөөд оролцох хүний нэрсийг өгнө.

Үнэлгээний өмнөх уулзалтын зорилго нь уралдаант шалгаруулалтын баримт бичигтэй холбоотой аливаа асуултад хариулт өгөх, тодруулга хийхэд оршино. Уулзалтын үеэр өгсөн хариулт, энэхүү баримт бичгийн 3.4-ийн дагуу өгсөн хариулт хоорондоо зөрсөн тохиолдолд албан бичгээр өгсөн хариултыг хүчинтэйд тооцно. Үнэлгээний өмнөх уулзалтын үеэр тавигдсан асуултууд тэдгээрийн хариултуудыг багтаасан уулзалтын тэмдэглэлийг бүх оролцогчид хүргүүлнэ. Уулзалтад оролцоогүй, уулзалтын үеэр аливаа тодруулга хүсээгүй нь оролцогчийг шаардлага хангаагүйд тооцох үндэслэл болохгүй.

Оролцогч шаардлагатай бол төслийн талбай, газартай танилцаж болно. Үүнтэй холбогдон гарах аливаа зардал, эрсдэлийг оролцогч өөрсдөө хариуцна.

### 3.6 Уралдаант шалгаруулалтын баримт бичгийг хүчингүй болгох, нэмэлт, өөрчлөлт оруулах

Ажлын хэсэг төслийн санал хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө уралдаант шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулахаар бол түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар батлуулна. Энэ тохиолдолд төслийн санал хүлээн авах эцсийн хугацааг нэмэлт, өөрчлөлт оруулсан өдрөөс хойш 10 (арав)-аас доошгүй өдрөөр ажлын хэсгээс шаардлагатай гэж үзсэн хугацаагаар сунгана. Ийнхүү хийгдсэн аливаа нэмэлт, өөрчлөлт нь уралдаант шалгаруулалтын баримт бичгийн салшгүй хэсэг болох бөгөөд бүх оролцогчид нэгэн зэрэг бичгээр мэдэгдэнэ.

### 3.7 Төслийн санал

#### 3.7.1 Төслийн саналын иж бүрдэл, төслийн санал ирүүлэх

Төслийн саналын иж бүрдэл нь дараах хэсгээс бүрдэнэ:

3.7.1.1. Төслийн саналын мэдүүлэг;

3.7.1.2. Төслийн саналын баталгаа;

3.7.1.3. Техникийн саналын багц;

3.7.1.4. Санхүүгийн саналын багц.

Төслийн саналын мэдүүлэг, төслийн саналын баталгааг хамтад нь нэг дугтуйнд хийж энэ жишиг баримт бичгийн 3.12.1-д заасны дагуу битүүмжилнэ.

Техникийн саналын багцад техникийн саналын 1 (нэг) эх хувь, [шаардлагатай хуулбар хувийн тоо] хуулбар хувь, 1 (нэг) цахим хувь байна. Техникийн саналын эх хувь, хуулбар хувиуд, цахим хувийг тус тусад нь энэ жишиг баримт бичгийн 3.11.2-т заасан тэмдэглэгээ бүхий дугтуйнуудад (дотор дугтуй) хийж битүүмжлэн, тэдгээрийг энэ жишиг баримт бичгийн 3.11.1-д заасны дагуу дахин давхар нэг дугтуйнд хийж битүүмжилнэ (гадна битүүмжлэл).

Санхүүгийн саналын багцад санхүүгийн саналын 1 (нэг) эх хувь, [шаардлагатай хуулбар хувийн тоог бичих] хуулбар хувь, 1 (нэг) цахим хувь байна. Санхүүгийн саналын эх хувь, хуулбар хувиуд, цахим хувийг тус тусад нь энэ жишиг баримт бичгийн 3.11.2-т заасан бичиглэл бүхий дугтуйнуудад (дотор дугтуй) хийж битүүмжлэн, тэдгээрийг энэ жишиг баримт бичгийн 3.11.1-д заасны дагуу дахин давхар нэг дугтуйд хийж битүүмжилнэ (гадна битүүмжлэл).

Төслийн саналын цахим хувиудыг Microsoft Excel, Adobe PDF хэлбэрүүдээр бэлтгэн CD-нд буулгасан байна.

Техникийн болон санхүүгийн саналын эх болон хуулбар хувь хоорондоо зөрсөн тохиолдолд эх хувийг баримтална. Төслийн саналын иж бүрдлийг энэхүү уралдаант шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлагад нийцүүлэн бэлтгэж ирүүлэх бөгөөд уралдаант шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлагад нийцээгүй тэмдэглэгээ, уралдаант шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлагад нийцээгүй гадна битүүмжлэлтэй төслийн саналыг хүлээж авахгүй.

Оролцогч төслийн саналыг доорх хаягаар [төслийн санал хүлээн авах эцсийн хугацаа]-аас өмнө ирүүлэх бөгөөд заасан хугацаанаас хоцорсон, гадна битүүмжлэл дээрх шаардлагыг хангаагүй төслийн саналыг хүлээж авахгүй.

[ажлын хэсгийн нарийн бичгийн даргын хаяг]

### 3.7.2 Төслийн саналд нэмэлт, өөрчлөлт оруулах, буцаан авах

Оролцогч нь төслийн санал хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө өөрийн хүргүүлсэн төслийн саналдаа нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Хэрэв төслийн саналд нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд төслийн санал хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө энэ тухайгаа албан бичгээр хүсэлт гарган, нэмэлт, өөрчлөлт оруулсан төслийн саналын хамт ажлын хэсэгт ирүүлнэ. Ажлын хэсэг өмнө ирүүлсэн төслийн саналыг нээлгүйгээр эргүүлэн олгоно.

Оролцогч өөрийн төслийн саналыг буцаан авах хүсэлтийг төслийн санал хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө хэдийд ч албан бичгээр мэдэгдэж болно. Ажлын хэсэг төслийн саналаа буцаан авах хүсэлтэд үндэслэн оролцогчийн төслийн саналыг нээлгүйгээр эргүүлэн олгох бөгөөд төслийн саналын баталгааг гүйцэтгүүлнэ.

### 3.7.3 Төслийн санал бэлтгэх зардал

Оролцогч төслийн санал бэлтгэх, ирүүлэхтэй холбогдон гарах бүх зардлыг хариуцах бөгөөд ажлын хэсэг болон төрийн түншлэгч ямар ч нөхцөлд энэхүү зардалтай холбогдох хариуцлага хүлээхгүй.

### 3.7.4 Түншлэлийн гэрээний төсөлд өөрчлөлт оруулах

Оролцогчийн бэлтгэж ирүүлсэн түншлэлийн гэрээний төсөл нь уралдаант шалгаруулалтын баримт бичигт тусгасан түншлэлийн гэрээний төслөөс эрс өөрчлөгдсөн, тодорхой бус эсхүл хүлээн зөвшөөрөх боломжгүй заалтуудтай байх тохиолдолд төслийн саналыг үнэлэхэд оноог бууруулж тооцох үндэслэл болно.

### 3.7.5 Оролцогчийн батламжлал

Оролцогч төслийн санал ирүүлснээр уралдаант шалгаруулалтын баримт бичиг, төслийн гэрээнүүдийн төсөлтэй сайтар танилцаж ойлгосон, Монгол Улсын хууль тогтоомжуудыг судалсан бөгөөд тэдгээр хууль тогтоомжийг дагаж мөрдөх нь төслийн гэрээний дагуу хийгдэх үйл ажиллагааг гүйцэтгэхэд ямар нэгэн нөлөө үзүүлэхгүй болохыг хүлээн зөвшөөрч, баталгаажуулж байгааг илэрхийлнэ. Оролцогч нь төрийн түншлэгчийн төлөөлөл эсхүл ажлын хэсгийн гишүүнтэй хийсэн аливаа аман яриа, хэлцэл нь төслийн гэрээний дагуу хүлээсэн нөхцөл, үүргүүдэд нөлөө үзүүлэх буюу өөрчлөлт оруулахгүй гэдгийг хүлээн зөвшөөрнө.

Оролцогч уралдаант шалгаруулалтын баримт бичигт тусгасан мэдээллийг өөрийнхөөрөө тайлбарлан ойлгох бөгөөд төрийн түншлэгч, түүний ажилтан, ажлын хэсэг, түүний гишүүн үүнтэй холбогдуулан ямар нэг хариуцлага хүлээхгүй. Оролцогч аливаа баримт бичиг, төслийн талбайг үзэж шалгахдаа алдаа гаргасан, орхигдуулсан байх нь төслийн санал, төслийн гэрээнээс хамааран хүлээх аливаа үүрэг, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

## 3.8 Техникийн санал бэлтгэх

Оролцогчийн ирүүлэх техникийн санал нь тухайн оролцогч төслийн үр дүнд тавигдах шаардлага (Хавсралт 6.3) болон түншлэлийн гэрээний дагуу хувийн хэвшлийн түншлэгчийн зайлшгүй гүйцэтгэх үйл ажиллагааг явуулах чадвартай гэдгийг батлан харуулах шаардлагатай.

Техникийн саналд дараах мэдээллийг тусгасан байна:

### 3.8.1 Техникийн төлөвлөгөө

Төслийн үр дүнд тавигдах шаардлагуудыг хэрхэн хангах талаар техникийн төлөвлөгөө, бусад нэмэлт мэдээллүүд;

### 3.8.2 Түншлэлийн гэрээнүүдийн төсөлд оруулсан өөрчлөлт

Түншлэлийн гэрээний төсөлд оруулсан өөрчлөлтийн тойм, ямар үндэслэлээр өөрчлөлт оруулсныг тайлбарласан байх;

### 3.8.3 Түншлэлийн гэрээний төслийн хавсралтууд

Түншлэлийн гэрээний төслийн дараах хавсралтыг бэлтгэж ирүүлнэ:

3.8.3.1. Зураг төсөл, техникийн үзүүлэлт;

3.8.3.2. Барилгын ажлын төлөвлөгөө;

3.8.3.3. Шалгах, хүлээлгэн өгөх төлөвлөгөө;

3.8.3.4. Ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөө;

3.8.3.5. Засвар, арчлалтын төлөвлөгөө;

3.8.3.6. Шилжүүлэн өгөх төлөвлөгөө.

### 3.8.4 Бусад шаардлагатай мэдээллүүд

Оролцогчийн зүгээс шаардлагатай гэж үзсэн бусад нэмэлт мэдээлэл, лавлагаа.

## 3.9 Санхүүгийн санал бэлтгэх

Оролцогчийн ирүүлэх санхүүгийн санал нь тухайн оролцогч түншлэлийн гэрээний дагуу хувийн хэвшлийн түншлэгчийн зайлшгүй гүйцэтгэх үйл ажиллагааг явуулах боломжтой гэдгийг батлан харуулах шаардлагатай. Санхүүгийн саналд дараах мэдээллийг тусгана:

### 3.9.1 Төслийн зардлын задаргаа:

Төслийн хөрөнгө оруулалтын болон үйл ажиллагааны зардлын дэлгэрэнгүй задаргаа.

### 3.9.2 Санхүүжилтийн төлөвлөгөө:

Оролцогч төслийн санхүүжилтийн дэлгэрэнгүй төлөвлөгөөг Хавсралт 6.1-ийн Маягт 7-гийн дагуу бэлтгэж ирүүлнэ. Санхүүжилтийн төлөвлөгөөнд өөрийн хөрөнгөө хувь эзэмшигч бүрээр харуулсан задаргаа, зээлийн хөрөнгийг санхүүжүүлэгч бүрээр харуулсан задаргаа, зээлийн эргэн төлөлтийн хуваарь, зээлийн хүү болон бусад төлбөр хураамжийг дэлгэрэнгүй тусгана. Санхүүжилтийн төлөвлөгөө нь түншлэлийн гэрээний нийт хугацааг хамарсан байна.

### 3.9.3 Санхүүгийн загвар:

Санхүүгийн загвар нь дараах шаардлагыг хангасан байна:

3.10.3.1. Түншлэлийн гэрээ, бусад нэмэлт гэрээ, санхүүжилтийн төлөвлөгөөтэй уялдаатай байх;

3.10.3.2. Дэлгэрэнгүй тайлбартай ямар нэгэн нууц үг, хамгаалалтгүй, Microsoft Excel программ дээр бэлтгэсэн байх;

3.10.3.3. Санхүүгийн загварын суурь огноо нь [тоо] байх;



3.10.3.4. Барилгын ажлын үед сар бүрээр, түүнээс хойш хагас жилээр огноог оруулж, жилийн тоймыг жил тус бүрээр түншлэлийн гэрээний хугацааны турш харуулсан байх;

3.10.3.5. Бүх тоон өгөгдлийг нэрлэсэн, бодит үнээр харуулсан байх (тооцоонд ашиглах хөнгөлөлтийн хувь [хувь] байна);

3.10.3.6. Санхүүгийн загвар нь дараах зүйлсийг харуулах боломжтой байна:

- Инфляцын таамаглал;
- Гадаад валютын ханшийн нөлөө, төгрөгийн ханшны тооцоо;
- Санхүүгийн загварт тусгасан татваруудын тодорхойлолт, тайлбар;
- Төслийн санхүүжилтийн эх үүсвэр, зарцуулалтын хүснэгт;
- Хөрөнгө оруулалтын зардлын задаргаа;
- Төсөл эхлэлтийн зардал;
- Зээлийн санхүүжилтийн хувьд санхүүжүүлэгч бүрээр зээлийн үйлчилгээний хуваарь;
- Нийт хөрөнгө оруулалт;
- Үйл ажиллагааны зардлын тооцоо;
- Засвар арчлалтын зардлын тооцоо;
- Баланс, орлого үр дүн, мөнгөн урсгалын тооцоо;
- Гадаад валютаар тооцоо хийгдэх бүтээгдэхүүн, үйлчилгээ;
- Бүх төрлийн татваруудын таамаглал, татварыг тооцох, үл тооцох тохиолдлуудыг харуулах боломжтой байх;
- Энэхүү уралдаант шалгаруулалтын баримт бичигт тусгасан хөнгөлөлтийн хувиар тооцсон бодит орлогын өнөөгийн үнэ цэнэ;
- Татварын өмнөх болон татварын дараах бодит болон нэрлэсэн өгөөжийн дотоод хувь;
- Бодит болон нэрлэсэн өөрийн хөрөнгийн өгөөж;
- Хөрөнгө оруулалтын зардлын мэдрэмжийн шинжилгээ;
- Үйл ажиллагааны зардлын мэдрэмжийн шинжилгээ;
- Хүүгийн мэдрэмжийн шинжилгээ;
- Зээлийн хугацааны мэдрэмжийн шинжилгээ;
- Инфляцын мэдрэмжийн шинжилгээ;
- Төгрөгийн ханшны өөрчлөлт, валютын ханшны өөрчлөлтийн мэдрэмжийн шинжилгээ;
- Өр, өөрийн хөрөнгийн харьцаа;
- Санхүүжүүлэгчийн шаардсан бусад харьцаанууд.

3.9.4 Улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилд үзүүлэх нөлөөний танилцуулга:

Оролцогч тус төслийг хэрэгжүүлснээр улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилд үзүүлэх нөлөөний талаар дэлгэрэнгүй мэдээллийг бэлтгэж ирүүлнэ.

### 3.9.5 Бусад санхүүгийн мэдээлэл:

Оролцогч Хавсралт 6.1 Маягт 4-ийн дагуу бэлтгэсэн Зээл олгохыг зөвшөөрсөн тухай мэдэгдэл, Хавсралт 6.1 Маягт 5-ын дагуу бэлтгэсэн Хөрөнгө оруулах тухай мэдэгдлийг шаардлагатай тоо хэмжээгээр бэлтгэж ирүүлнэ.

## 3.10 Төслийн баталгааны шаардлага

### 3.10.1 Төслийн саналын баталгаа:

Оролцогч [дүн] үнийн дүн бүхий төслийн саналын баталгааг Хавсралт 6.1-ийн Маягт 2-ын дагуу Монгол Улсын эсхүл эрх бүхий этгээдийн хүлээн зөвшөөрч болох банкнаас гаргуулж ирүүлнэ. Төслийн саналын баталгаа ирүүлээгүй бол төслийн саналыг нээхгүйгээр буцааж үнэлгээнд тэнцээгүйд тооцно. Төслийн саналын баталгааны хүчинтэй хугацаа нь төслийн саналын хүчинтэй байх хугацаатай адил төслийн санал хүлээн авах эцсийн хугацаанаас хойш [365 (гурван зуун жаран таван)] хоног байна. Ажлын хэсгээс ирүүлсэн төслийн саналын хүчинтэй байх хугацааг сунгах хүсэлтийг зөвшөөрсөн тохиолдолд төслийн саналын баталгааны хүчинтэй хугацааг шаардлагатай хоногоор сунгаж ажлын хэсэгт оролцогч өөрийн зардлаар хүргүүлнэ.

Оролцогч төслийн саналын хүчинтэй байх хугацааг сунгахаас татгалзсан эсхүл энэ жишиг баримт бичгийн 3.12-т заасны дагуу шаардсан хугацаанд хариу ирүүлээгүй тохиолдолд төслийн саналаа буцаан татсан гэж үзэж төслийн саналын баталгааг гүйцэтгүүлэхгүйгээр цуцална.

Уралдаант шалгаруулалтаар шалгараагүй оролцогчийн төслийн саналын баталгааг төслийн санал хүчинтэй байх хугацаа эсхүл шалгарсан оролцогч түншлэлийн гэрээнд гарын үсэг зурсан өдрийн аль өмнөхөд нь цуцална.

Уралдаант шалгаруулалтаар шалгарсан оролцогч энэ жишиг баримт бичгийн 3.10.2-т заасны дагуу түншлэлийн гэрээ байгуулах тухай мэдэгдэлд гарын үсэг зуран, гүйцэтгэлийн баталгааг ирүүлмэгц түүний төслийн саналын баталгааг цуцална.

Оролцогч төслийн саналын баталгааны хүчинтэй байх хугацаанд төслийн саналаа буцааж авах тохиолдолд төслийн саналын баталгааг гүйцэтгүүлэх бөгөөд шалгарсан оролцогчийн хувьд энэ жишиг баримт бичгийн 3.10.2-т заасны дагуу түншлэлийн гэрээ байгуулах тухай мэдэгдэлд гарын үсэг зураагүй эсхүл гүйцэтгэлийн баталгааг ирүүлээгүй тохиолдолд төслийн саналын баталгааг гүйцэтгүүлнэ.

### 3.10.2 Түншлэлийн гэрээ байгуулах тухай мэдэгдэл:

Ажлын хэсгээс түншлэлийн гэрээний нөхцөлийг хамгийн сайн харилцан тохиролцсон оролцогчид гүйцэтгэлийн баталгаа болон түншлэлийн гэрээ байгуулах тухай мэдэгдэл ирүүлэх хүсэлтийг явуулна. Хүсэлт явуулснаас хойш 10 (арван) өдрийн дотор Хавсралт 6.1-ийн Маягт 8-ын дагуу бэлтгэсэн [дүн] үнийн дүн бүхий гүйцэтгэлийн баталгааг Хавсралт 6.1-ийн Маягт 3-ын дагуу бэлтгэж гарын үсэг зурсан түншлэлийн гэрээ байгуулах тухай мэдэгдлийн хамт уралдаант шалгаруулалтын ажлын хэсэгт ирүүлнэ.

### 3.10.3 Гүйцэтгэлийн баталгаа:

Гүйцэтгэлийн баталгааны үнийн дүн [дүн] байна. Гүйцэтгэлийн баталгааг Хавсралт 6.1-ийн Маягт 8-ын дагуу гаргана.

### 3.11 Төслийн саналын битүүмжлэл, тэмдэглэгээ

Энэхүү уралдаант шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлагын дагуу битүүмжилж, тэмдэглэгээ хийгээгүйгээс төслийн санал буруу хаягаар хүргэгдсэн эсхүл төслийн саналыг нээхээс өмнө битүүмжлэл задарвал ажлын хэсэг хариуцлага хүлээхгүй бөгөөд төслийн саналаас шаардлага хангаагүй гэсэн үндэслэлээр татгалзаж болно.

#### 3.11.1 Төслийн саналын иж бүрдлийн битүүмжлэл, тэмдэглэгээ:

Төслийн саналын иж бүрдлийг Техникийн саналын багц, Санхүүгийн саналын багц, Төслийн саналын мэдүүлэг болон төслийн саналын баталгаа гэсэн 3 дугтуйнд хийж битүүмжлэн (гадна битүүмжлэл) дугтуйн зүүн дээд буланд доорх тэмдэглэгээг хийнэ:

- Уралдаант шалгаруулалтын баримт бичгийн дугаар;
- Төслийн нэр;
- Багцын нэр ([“Техникийн саналын багц”, “Санхүүгийн саналын багц”, “Төслийн саналын мэдүүлэг болон төслийн саналын баталгаа”-ны аль тохирохыг бичих])
- Төслийн санал хүлээн авах эцсийн хугацаа;
- Төслийн санал ирүүлэх хаяг;
- Оролцогчийн нэр, хаяг.

#### 3.11.2 Саналын хувиудын тэмдэглэгээ:

Техникийн саналын битүүмжилсэн дугтуй тус бүрд доорх тэмдэглэгээг хийнэ:

ТЕХНИКИЙН САНАЛ ([ЭХ ХУВЬ, ХУУЛБАР ХУВЬ, ЦАХИМ ХУВЬ-ийн аль тохирохыг бичих])

[ТӨСЛИЙН НЭР, ДУГААР]

ОРОЛЦОГЧ .....

ХАЯГ .....

Санхүүгийн саналын битүүмжилсэн дугтуй тус бүрд доорх тэмдэглэгээг хийнэ:

САНХҮҮГИЙН САНАЛ ([ЭХ ХУВЬ, ХУУЛБАР ХУВЬ, ЦАХИМ ХУВЬ-ийн аль тохирохыг бичих])

[ТӨСЛИЙН НЭР, ДУГААР]

ОРОЛЦОГЧ.....

ХАЯГ.....

### 3.12 Төслийн санал хүчинтэй байх хугацаа

Оролцогчийн ирүүлсэн төслийн санал нь төслийн санал хүлээн авах эцсийн хугацаанаас хойш [хугацаа] хоног хүчинтэй байна. Энэ хугацаанд түншлэлийн гэрээнд гарын үсэг зурж амжаагүй бол ажлын хэсэг төслийн санал хүчинтэй байх хугацаа дуусахаас 30 (гуч)-аас багагүй өдрийн өмнө оролцогчдод төслийн санал хүчинтэй байх хугацааг сунгах тухай, хэдий хугацаагаар сунгахыг заасан албан бичиг хүргүүлж хүчинтэй байх хугацааг нь сунгаж болно. Оролцогч төслийн санал хүчинтэй байх хугацааг сунгахыг зөвшөөрсөн тохиолдолд төслийн санал

хүчинтэй байх хугацааг сунгах тухай албан бичгийг хүлээн авснаас хойш 10 /арван/ өдрийн дотор зөвшөөрсөн тухай албан бичгийг хүчинтэй хугацааг нь шаардлагатай хугацаагаар сунгасан төслийн саналын баталгааны хамт ирүүлнэ. Төслийн саналын хүчинтэй байх хугацааг сунгахаас татгалзсан эсхүл шаардсан хугацаанд хариу ирүүлээгүй тохиолдолд төслийн саналыг буцаан татсанд тооцно.

### 3.13 Төслийн санал хүлээн авах

#### 3.13.1 Төслийн санал хүлээн авах, мэдээлэл хийх

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга [төслийн санал хүлээн авах эцсийн хугацааг бичих] цагаас өмнө ирүүлсэн төслийн саналын гадна битүүмжлэл, тэмдэглэгээг шалган энэхүү уралдаант шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлагыг хангасан бол бүртгэж, хүлээн авах бөгөөд шаардлага хангаагүй бол хүлээн авахгүй.

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга [мэдээлэл хийх газар, огноо, цаг] цагт оролцогчдын талаар ерөнхий мэдээлэл хийнэ. Ерөнхий мэдээлэл хийх үед оролцогчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч болон сонирхсон бусад этгээд байлцаж болно. Ерөнхий мэдээлэл хийх үед хийсэн тэмдэглэлд ажлын хэсгийн нарийн бичгийн дарга болон байлцсан бусад этгээд гарын үсэг зурна.

### 3.14 Нууцлал

Ажлын хэсэг нь төслийн саналд ирүүлсэн аливаа мэдээллийг шалгах, үнэлэх зорилгоор холбогдох байгууллага, зөвлөхүүдэд танилцуулах эрхтэй. Эрх бүхий этгээд, ажлын хэсэг, төслийн саналын мэдээлэлтэй танилцсан бусад этгээд нь оролцогчийн төслийн саналд ирүүлсэн мэдээллийг шалгах, үнэлэхээс бусад зорилгоор цааш задруулахыг хориглоно.

Уралдаант шалгаруулалт явагдаж дуусмагц оролцогчийн ирүүлсэн төслийн саналын хуулбар хувиудыг устгах бөгөөд эх хувийг зохих журмын дагуу уралдаант шалгаруулалтын хавтаст хэргийн хамт архивд шилжүүлнэ.

### 3.15 Ажлын хэсэг тодруулга хүсэх

Ажлын хэсгээс төслийн саналтай холбоотой аливаа тодруулга авах хүсэлтийг эрх бүхий этгээдийн албан тоотоор оролцогчид хүргүүлнэ. Оролцогч нь хүсэлт хүлээн авсан өдрөөс хойш 5 (таван) өдрийн дотор тодруулгыг бичгээр ирүүлнэ.

## 4 Төслийн саналын үнэлгээ

### 4.1 Үнэлгээний дараалал

Төслийн саналыг Хувийн хэвшлийн түншлэгчийг болон зөвлөх үйлчилгээг сонгон шалгаруулах журмын дагуу үнэлэх бөгөөд эхлээд техникийн саналыг үнэлнэ. Үнэлгээгээр техникийн санал нь тэнцсэн оролцогчдын санхүүгийн саналыг үнэлж, дараалуулсан жагсаалтыг гаргана.

### 4.2 Төслийн саналаас татгалзах эрх

Ажлын хэсэг нь оролцогчийн төслийн санал худал хуурмаг, бүрэн бус, зарим мэдээллийг нуун дарагдуулсан гэж үзсэн эсхүл оролцогчид урьдчилсан шалгаруулалтын үед тавигдсан ерөнхий шаардлага болон чадварын шалгууртай холбоотой ямар нэг өөрчлөлт гарсныг уралдаант шалгаруулалтын ажлын хэсэгт мэдэгдээгүй эсхүл мэдэгдсэн боловч уралдаант шалгаруулалтын ажлын хэсэг

тухайн өөрчлөлт нь оролцогчийг ерөнхий шаардлага болон чадварын шалгуурыг хангахгүй болгож байгаа гэж үзэх тохиолдолд тухайн төслийн саналаас татгалзах эрхтэй байна.

#### 4.3 Техникийн саналын үнэлгээ

Оролцогчийн ирүүлсэн техникийн санал бүрэн бус бол техникийн саналын үнэлгээгээр тэнцээгүйд тооцно. Техникийн саналыг шалгуур үзүүлэлт тус бүрээр оноогоор үнэлнэ. Техникийн саналын үнэлгээгээр тэнцэхийн тулд шалгуур үзүүлэлтүүдийн оноог жигнэн нэгтгэсний дараа дундаж оноо хамгийн багадаа 60 байна.

Техникийн саналыг үнэлэх шалгуур үзүүлэлтүүдийн хүснэгт\*

Шалгуур үзүүлэлтүүд	Жин (%)
Техникийн үзүүлэлт, үйл ажиллагааны үнэлгээ Оролцогчийн ирүүлсэн техникийн төлөвлөгөө, Түншлэлийн гэрээний хавсралт болох зураг төсөл, техникийн үзүүлэлтүүд, барилгын ажлын төлөвлөгөө, шалгах, хүлээлгэн өгөх төлөвлөгөө, ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөө, Засвар, арчлалтын төлөвлөгөө, Шилжүүлэн өгөх төлөвлөгөө зэрэгт үндэслэн үнэлгээг хийнэ	[ ]
Үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмж Оролцогчийн ирүүлсэн Түншлэлийн гэрээний хавсралт болох Ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөө, Шилжүүлэн өгөх төлөвлөгөө зэрэгт үндэслэн үнэлгээг хийнэ	[ ]
Түншлэлийн гэрээний төслийн ерөнхий нөхцөлийн үнэлгээ Оролцогчийн ирүүлсэн төслийн гэрээнүүдийн төсөлд оруулсан өөрчлөлтийн тоймд үндэслэн үнэлгээг хийнэ	[ ]
Байгаль орчныг хамгаалах шаардлага хангаж байгаа эсэх Оролцогчийн ирүүлсэн Түншлэлийн гэрээний хавсралт болох Ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөөнд үндэслэн үнэлгээг хийнэ	[ ]

\*Техникийн болон санхүүгийн санал үнэлэх шалгуур үзүүлэлтүүдэд Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд заасны дагуу шаардлагатай гэж үзсэн бусад шалгуур үзүүлэлтийг нэмж болно.

#### 4.4 Санхүүгийн саналын үнэлгээ

Санхүүгийн саналыг үнэлэх шалгуур үзүүлэлт тус бүрээр оноогоор үнэлж, авсан оноонуудыг жигнэн нэгтгэх замаар дундаж оноог тооцож гаргана.

Санхүүгийн саналыг үнэлэх шалгуур үзүүлэлтүүдийн хүснэгт\*

Шалгуур үзүүлэлтүүд	Жин (%)
Санхүүгийн загварын үнэлгээ Оролцогчийн ирүүлсэн Санхүүгийн загварт үндэслэн түншлэлийн гэрээний хугацаанд гүйцэтгэх ажил, үзүүлэх үйлчилгээний үнэ, төлбөрийн тухайн үеийн нийт хэмжээ, тэдгээрийн өнөөгийн үнэ цэнийг харгалзан үзэж үнэлгээг хийнэ	[ ]
Төслийн зардлын үнэлгээ Оролцогчийн ирүүлсэн Төслийн зардлын задаргаанд үндэслэн зураг төсөл, барилгын ажлын өртөг, урсгал зардал, нийт хөрөнгө оруулалтын хэмжээ, өнөөгийн үнэ цэнийг харгалзан үзэж үнэлгээг хийнэ	[ ]

Санхүүжилтийн төлөвлөгөө Оролцогчийн ирүүлсэн Санхүүжилтийн төлөвлөгөөнд үндэслэн үнэлгээг хийнэ	[ ]
Улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилд үзүүлэх нөлөө Оролцогчийн ирүүлсэн тус төслийг хэрэгжүүлснээр улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилд үзүүлэх нөлөөний танилцуулгад үндэслэн үнэлгээг хийнэ	[ ]

*\*Техникийн болон санхүүгийн санал үнэлэх шалгуур үзүүлэлтүүдэд Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд заасны дагуу шаардлагатай гэж үзсэн бусад шалгуур үзүүлэлтийг нэмж болно.*

Ажлын хэсэг нь оролцогчийн төслийн саналын үнэлгээнд авсан нийлбэр дүнг гаргахдаа техникийн болон санхүүгийн саналын үнэлгээний дүнг жигнэн нэгтгэж тооцно. Техникийн саналын үнэлгээний нийт оноонд эзлэх жин [...], санхүүгийн саналын үнэлгээний нийт оноонд эзлэх жин [...] байна.

#### 4.5 Түншлэлийн гэрээ байгуулах

Ажлын хэсэг нь дараалуулсан жагсаалтын эхний оролцогчийг түншлэлийн болон холбогдох бусад гэрээний нөхцөлийн талаар хэлэлцээнд урина. Дараалуулсан жагсаалтын эхний оролцогчтой хэлэлцээ хийгээд гэрээний нөхцөлийг харилцан тохирч чадаагүй тохиолдолд жагсаалтын дараагийн оролцогчийг хэлэлцээнд урьж болно.

Эрх бүхий этгээдээс түншлэлийн гэрээний нөхцөлийг хамгийн сайн харилцан тохиролцсон нэг оролцогчтой гэрээ байгуулах дүгнэлт гаргаж Засгийн газарт хүргүүлэн, гэрээ байгуулах тухай зөвшөөрөл авбал тухайн оролцогчид түншлэлийн гэрээ байгуулах тухай мэдэгдэл ирүүлэх хүсэлтийг явуулна.

Хүсэлт явуулсан өдрөөс хойш 10 (арван) өдрийн дотор түншлэлийн гэрээ байгуулах тухай мэдэгдлийг Хавсралт 1-ийн Маягт 3-ын дагуу гаргаж гүйцэтгэлийн баталгааны хамт ирүүлнэ.

Түншлэлийн гэрээг байгуулахаас өмнө тусгай зориулалтын компанийг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу байгуулах бөгөөд дараах баримт бичгийн баталгаажуулсан хуулбарыг ажлын хэсэгт ирүүлнэ:

- а. Компанийн гэрчилгээ, үүсгэн байгуулах шийдвэр, дүрэм;
- б. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн нэрсийн жагсаалт;
- в. Бүртгэгдсэн ажлын байрны байршил.

#### 4.6 Түншлэлийн гэрээг байгуулах зардал болон эрсдэл

Шалгарсан оролцогч нь түншлэлийн гэрээний хэлэлцээр хийх болон эцэслэн зурахтай холбогдон гарах аливаа зардал, мэргэжлийн зөвлөхийн зардал, бусад зардлыг бүрэн хариуцна. Төрийн түншлэгч, зохицуулах байгууллага, сонгон шалгаруулалтын ажлын хэсэг, түүний гишүүд, тэдгээрийн төлөөлөгчдийн өгсөн мэдээлэл болон төсөлтэй холбогдуулан гаргасан оролцогчийн шийдвэрт аливаа хариуцлага хүлээхгүй.

### 5 Түншлэлийн гэрээ

#### 5.1 Танилцуулга

Түншлэлийн гэрээ нь түншлэлийн [гэрээ, бусад нэмэлт] гэрээнээс бүрдэнэ. Уралдаант шалгаруулалтын баримт бичигт төсөл хэрэгжүүлэх нөхцөлийг

тусгасан түншлэлийн гэрээний төслийг [бусад нэмэлт гэрээнүүдийн төслийн хамт] (Хавсралт 6.2) хавсаргав.

Оролцогч нь түншлэлийн гэрээний [төсөл болон бусад нэмэлт гэрээний] төсөлд үндэслэн төслийн саналаа боловсруулж ирүүлэх бөгөөд зохих мэдээлэл, шаардлагатай өөрчлөлтийг оруулсан төслийн гэрээний төсөл, оруулсан өөрчлөлтийн тоймыг техникийн саналд ирүүлнэ.

Оролцогчийн ирүүлсэн түншлэлийн гэрээний төсөл нь уралдаант шалгаруулалтын баримт бичгийн түншлэлийн гэрээний төслөөс эрс өөрчлөгдсөн тохиолдолд төслийн саналыг үнэлэхэд оноог бууруулж тооцох үндэслэл болж болно.

## 5.2 Түншлэлийн гэрээ

Төрийн түншлэгч нь Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 26 дугаар зүйлд заасан гэрээ байгуулах зөвшөөрөл авч шалгарсан оролцогчтой түншлэлийн гэрээг байгуулна. Шалгарсан оролцогч түншлэлийн гэрээг байгуулснаар хувийн хэвшлийн түншлэгч болно.

[Түншлэлийн гэрээг [байгуулахтай хамт] [байгуулснаас хойш [боломжит хугацааг бичих] хугацаанд багтан] бусад нэмэлт гэрээнүүдийг байгуулснаар эсхүл нэмэлт гэрээний үүрэг хангагдсанаар түншлэлийн гэрээ хүчин төгөлдөр болох тухай заалтыг түншлэлийн гэрээнд оруулж болно.]

## 5.3 Нэмэлт гэрээ

[Төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх, баталгаа гаргах, шаардлагатай зөвшөөрөл, тусгай зөвшөөрөл авах, газар чөлөөлөхөд дэмжлэг үзүүлэх гэх мэт Түншлэлийн гэрээнд тусгасан нөхцөлтэй уялдуулан төрийн байгууллагатай нэмэлт гэрээ байгуулах шаардлагатай гэж үзвэл тодорхойлж бичих. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд заасан болон бусад асуудлаар төрийн түншлэгч, хувийн хэвшлийн түншлэгч, аливаа гуравдагч этгээд хооронд нэмэлт гэрээ байгуулах шаардлагатай гэж үзвэл тодорхойлж бичих.]

# 6 Хавсралтууд

## 6.1 Төслийн саналын маягт

### Маягт 1

Огноо:

Хэнд: [Эрх бүхий этгээдийн нэр]

[Уралдаант шалгаруулалтын баримт бичгийн дугаар]

[Төслийн нэр]

Төслийн саналын мэдүүлэг

Бид уралдаант шалгаруулалтын баримт бичиг, түүний бүх хавсралт, тэдгээрт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг бүрэн хүлээн авсан бөгөөд эдгээртэй сайтар танилцаж, бүрэн ойлгосон гэдгээ үүгээр нотолж байна.

Бид уралдаант шалгаруулалтын баримт бичигт тусгасан шаардлагуудад нийцүүлэн, оролцогчдод өгөх зааварчилгааны дагуу, төслийн саналаа үнэн зөв, бүрэн гүйцэд бэлтгэсэн бөгөөд, төслийн санал нь төслийн санал хүлээн авах

эцсийн хугацаанаас хойш [төслийн санал хүчинтэй байх хугацааг бичих] хоног хүртэл хүчинтэй, үл буцаах гэдгийг баталж, үүгээр хүргүүлж байна.

Уралдаант шалгаруулалтыг дуусах хүртэл бидэнтэй харилцах хаяг:

[Оролцогчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн нэр, холбоо барих хаяг]

Хүндэтгэсэн,

[Оролцогчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн нэр, албан тушаал, гарын үсэг ]

Хавсралт:

- Төслийн саналын баталгаа;
- Техник-эдийн засгийн үндэслэл;
- Техникийн саналын багц;
- Санхүүгийн саналын багц.

## Маягт 2

Огноо:

Хэнд: [Эрх бүхий этгээдийн нэр]

[Уралдаант шалгаруулалтын баримт бичгийн дугаар]

[Төслийн нэр]

Төслийн саналын баталгаа

[Банкны нэрийг бичих] банк нь Танай зарласан уралдаант шалгаруулалтын жишиг баримт бичгийн 3.10.1-д заасны дагуу [Оролцогчийн нэр] (цаашид “Оролцогч” гэх)-ийн төслийн саналд [төслийн саналын баталгааны үнийн дүн] төгрөгийн үл буцаах баталгааг дараах нөхцөлийн дагуу гаргаж байна:

1. Танай албан бичгээр ирүүлсэн хүсэлтийг хүлээн авснаар оролцогч эсхүл аливаа гуравдагч этгээдийн эсэргүүцлээс үл хамааран, тус баталгааг гүйцэтгүүлэх эрхтэй эсэх талаар нотолгоо шаардахгүйгээр дээр дурдсан үнийн дүнг танай заасан аль ч банкны дансанд нэн даруй шилжүүлэх буюу танай хүссэн хэлбэрээр төлөх болно.

2. Энэхүү баталгааг гаргаснаар бид үл маргалдах, үл буцах шууд үүргийг хүлээж байгаа бөгөөд ямар ч шалтгаанаар энэхүү үүргээсээ чөлөөлөгдөхгүй болно.

3. Энэхүү баталгаа нь [Төслийн санал хүчинтэй байх эцсийн хугацаа] өдрийг хүртэл хүчинтэй байх бөгөөд хүчинтэй хугацаа дуусахаас өмнө танайхаас гарын үсэг зурж албан бичгээр ирүүлсэн хүсэлтийн дагуу заасан хугацаагаар сунгах болно.

4. Энэхүү баталгаатай холбоотой аливаа асуудлыг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

[Баталгаа гаргасан банкны нэр, эрх бүхий албан тушаалтны нэр, албан тушаал, гарын үсгийг оруулах]

## Маягт 3

Огноо:

Хэнд: [Эрх бүхий этгээдийн нэр]



[Уралдаант шалгаруулалтын баримт бичгийн дугаар]

[Төслийн нэр]

Түншлэлийн гэрээ байгуулах тухай мэдэгдэл

Танай [огноо]-ний [түншлэлийн гэрээ байгуулах тухай мэдэгдэл ирүүлэх хүсэлтийг гаргасан албан бичгийн дугаар] албан бичгийн хариуд, уралдаант шалгаруулалтын жишиг баримт бичгийн 3.10.2-т заасны дагуу хүргүүлсэн төслийн санал, түншлэлийн гэрээний нөхцөлийн талаар хийсэн хэлэлцээнд үндэслэн, түншлэлийн гэрээг [түншлэлийн гэрээ байгуулах тухай мэдэгдэл ирүүлэх хүсэлтэд заасан огноо]-с өмнө байгуулах хүсэлтэй байгаа бөгөөд тус уралдаант шалгаруулалтын жишиг баримт бичгийн 5.3-т заасан нэмэлт гэрээг [огноо]-с өмнө байгуулах эрмэлзэлтэй, боломжтой гэдгээ үүгээр нотолж байна.

Үүнтэй холбогдуулан [төслийн компанийн гэрчилгээ, төлөөлөн удирдах зөвлөлийн нэрсийн жагсаалт, бүртгэгдсэн ажлын байршлын мэдээлэлтэй хамт] хавсралтаар хүргүүлж байна.

[Оролцогчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн нэр, албан тушаал, гарын үсэг ]

Хавсралт:

- Төслийн компанийн гэрчилгээ;
- Төлөөлөн удирдах зөвлөлийн нэрсийн жагсаалт;
- Бүртгэгдсэн ажлын байршил.

#### Маягт 4

Огноо:

Хэнд: [Оролцогчийн нэр]

[Уралдаант шалгаруулалтын баримт бичгийн дугаар]

[Төслийн нэр]

Зээл олгохыг зөвшөөрсөн тухай мэдэгдэл

Бид [уралдаант шалгаруулалтын баримт бичгийн дугаар] бүхий уралдаант шалгаруулалтын баримт бичиг, холбогдох гэрээний төсөл, төслийн материалтай танилцсан бөгөөд [түншлэл эсхүл байгууллага] тус уралдаант шалгаруулалтад ялбал [банкны нэр] банкны зээлийн хорооны шийдвэрээс шалтгаалан [үнийн дүн] төгрөгийн зээл олгохыг зөвшөөрч байна.

Мөн түүнчлэн [эрх бүхий этгээдийн нэр]-ийн эрх ашигт нийцүүлэн дор дурдсан зүйлийг батламжилж байна:

1. Төслийн санал, гэрээнд нэмэлтээр аливаа өөрчлөлт оруулахыг шаардахгүй;
2. Тус уралдаант шалгаруулалтад заасан хугацаанд багтаан санхүүжилтийн гэрээг байгуулахад ямар нэгэн хүндрэл байхгүй болно.

Зээлийн нөхцөлийг энэхүү мэдэгдлийн хавсралтад тусгасан болно.

Хүндэтгэсэн,

---

[Санхүүжүүлэгчийн эрх бүхий албан тушаалтны гарын үсэг] Дээр дурдсан нөхцөлийг бид хүлээн зөвшөөрөв:

---

[Оролцогчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн гарын үсэг]

Хавсралт:

(1) Зээлийн нөхцөл

#### Маягт 5\*

Огноо:

Хэнд: [Эрх бүхий этгээдийн нэр]

[Уралдаант шалгаруулалтын баримт бичгийн дугаар]

[Төслийн нэр]

Хөрөнгө оруулах тухай мэдэгдэл

Бид хүргүүлсэн төслийн санал уралдаант шалгаруулалтад ялбал төслийн компанид энэхүү мэдэгдлийн хавсралтад тусгасан адилаар хөрөнгө оруулалт хийхээ нотолж, тус хөрөнгө оруулалтыг хийх чадвартайгаа харуулсан нотолгоог хавсралтаар хүргүүлж байна.

Хүндэтгэсэн,

[Төслийн компанид хөрөнгө оруулах түншлэлийн гишүүний удирдлагын нэр, албан тушаал, гарын үсэг ]

Хавсралт:

- Хөрөнгө оруулах хувь хэмжээ, үнийн дүнгийн мэдээлэл;
- Тус хөрөнгө оруулалтыг хийх чадвартайг харуулсан нотолгоо.

*\*Энэхүү маягтыг хөрөнгө оруулагчаар оролцож буй бүх гишүүн компаниуд бөглөж ирүүлнэ.*

#### Маягт 6

Огноо:

Хэнд: [Эрх бүхий этгээдийн нэр]

[Уралдаант шалгаруулалтын баримт бичгийн дугаар]

[Төслийн нэр]

Төслийн саналын хүчинтэй хугацааг сунгах тухай

Танай [огноо]-ний [төслийн саналын хүчинтэй хугацааг сунгах тухай хүсэлтийг гаргасан албан бичгийн дугаар] албан бичгийн хариуд, уралдаант шалгаруулалтын жишиг баримт бичгийн 3.10.1-д заасны дагуу төслийн саналын хүчинтэй хугацааг [эрх бүхий этгээдээс ирүүлсэн төслийн саналын хүчинтэй хугацааг сунгах тухай хүсэлтэд заасан хугацаа] өдрөөр сунгахыг зөвшөөрч байна.

Үүнтэй холбогдуулан [төслийн саналын баталгааг гаргасан банкны нэр] банкнаас гаргуулсан төслийн саналын баталгааг [дээрхтэй адил хугацаа] өдрөөр сунгахыг зөвшөөрч байгаагаа үүгээр нотлов.

Хүндэтгэсэн,

[Оролцогчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн нэр, албан тушаал, гарын үсэг ]

Маягт 7\*

Санхүүжилтийн төлөвлөгөө

Агуулга	Дүн /төгрөг/
Шаардлагатай санхүүжилт: [Шаардлагатай санхүүжилтийн задаргаа]	
Нийт шаардлагатай санхүүжилт	
Санхүүжилтийн эх үүсвэр: Өөрийн хөрөнгө [Зээлийн задаргаа]	
Нийт бүрдүүлсэн санхүүжилт	
Татахад бэлэн санхүүжилт: Өөрийн хөрөнгө [Зээлийн задаргаа]	
Нийт татахад бэлэн санхүүжилт	

*\*Санхүүжилтийн графикийг дэлгэрэнгүй харуулсан санхүүжилтийн төлөвлөгөөг Санхүүгийн загварт тусгасан байх шаардлагатай*

Маягт 8

Огноо:

Хэнд: [Эрх бүхий этгээдийн нэр]

[Уралдаант шалгаруулалтын баримт бичгийн дугаар]

[Төслийн нэр]

**ГҮЙЦЭТГЭЛИЙН БАТАЛГАА**

[Банкны нэр] банк нь тус уралдаант шалгаруулалтад ялсан [Оролцогчийн нэр] (цаашид “Оролцогч” гэх)-ийн хүсэлтээр, Танай зарласан уралдаант шалгаруулалтын жишиг баримт бичгийн 3.11.3-т заасны дагуу [гүйцэтгэлийн баталгааны үнийн дүн]

төгрөгийн үл буцаах баталгааг дараах нөхцөлийн дагуу гаргаж байна:

1. Танай албан бичгээр ирүүлсэн хүсэлтийг хүлээн авах бүрд, Оролцогч эсхүл аливаа гуравдагч этгээдийн эсэргүүцлээс үл хамааран тус баталгааг гүйцэтгүүлэх эрхтэй эсэх талаар нотолгоо шаардахгүйгээр хүсэлтэд ирүүлсэн үнийн дүнг (төлбөрийн нийт хэмжээ дээр дурдсан үнийн дүнгээс хэтрэхгүйгээр) танай заасан аль ч банкны дансанд нэн даруй шилжүүлэх буюу танай хүссэн хэлбэрээр төлөх болно.

2. Энэхүү баталгааг гаргаснаар бид үл маргалдах, үл буцах шууд үүргийг хүлээж байгаа бөгөөд ямар ч шалтгаанаар энэхүү үүргээсээ чөлөөлөгдөхгүй болно.

3.Энэхүү баталгаа нь [Гүйцэтгэлийн баталгааны хүчинтэй байх эцсийн хугацаа] өдрийг хүртэл хүчинтэй байна.

4.Энэхүү баталгаатай холбоотой аливаа асуудлыг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

[Баталгаа гаргасан банкны нэр, эрх бүхий албан тушаалтны нэр, албан тушаал, гарын үсгийг оруулах]

## 6.2 Түншлэлийн гэрээний төсөл

-----oOo-----